

## Dornogobi2010Re3

### **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР /2008-2012/-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ ТАЙЛАН**

2011 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2008-2012/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд аймаг, нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлэхээр тусгагдсан 178 зорилтыг хяналтанд авч хэрэгжилтийг зохион байгуулж ирлээ.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газраас 2010 оны 10 дугаар сард тус аймагт хийсэн шалгалтын багаас өгсөн зөвлөмжийг үндэслэн, бүрэн эрхийн өнгөрч байгаа хугацаанд нийт зорилтын мөн тийм хэмжээний хувийг хэрэгжүүлсэн байх учиртай гэсэн ерөнхий зарчмыг баримтлан үнэлгээ өгсөн болно.

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зорилт тус бүрийн хэрэгжилтэнд хувь тавьж үнэлгээ өгөхдөө тайлант хугацаанд бүрэн хэрэгжсэн байх, үлдэж байгаа хугацаанд дахин авч үзэхгүй зорилтын хэрэгжилтийг 100 хүртэл хувь, үргэлжлэн хэрэгжих зорилтыг 50 хүртэл хувь, хэрэгжиж эхлээгүй буюу хугацаа болоогүй зорилтыг ажлын эхлэл, явцыг харгалзан 0,0-30,0 хүртэл хувийн үнэлгээ өглөө.

Ийнхүү өгсөн үнэлгээгээр:

Хяналтанд авсан нийт зорилтын тоо	Хэрэгжилтийн явцын үнэлгээ							Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	Дундаж хувь
	0,0	10,0	30,0	50,0	70,0	90,0	100,0		
177	3		10	79	49	9	1	26	56,8

Дундаж хувь 56,8, үнэлгээний оноо 2,84 байна. 4 жилийн зорилтын 50,0 хувийг эхний хагаст хэрэгжүүлсэн байх утгаар нь тооцвол зорилт бүрэн хэрэгжиж байгаа үнэлгээ гарч байгаа юм.

/Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2008-2012/-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын дэлгэрэнгүй тайланг хавсаргав/

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР /2008-2012/-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ**

**/2010 оны жилийн эцсийн байдлаар/**

*НЭГ. ХҮН АМ, НИЙГМИЙН ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ИРГЭДИЙН АМЬДРАЛЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ*

№	Зорилтын дугаар, Зорилт	Хугацаа	Биелэлтийн явцын тухай тэмдэглэл	Хувь
<b>1.1. Эрүүл мэндийн бодлого</b>				
1	1.1.1.1. Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилтийн механизмыг төв, орон нутгийн түвшинд оновчтой болгоно	2008-2012	2010 онд 12 хөтөлбөрт 14 үйл ажиллагаа төлөвлөсөн, одоогийн байдлаар 6,8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, зорилтын 85,7 хувийг биелүүлээд байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 дугаар тогтоолоор аймгийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг шинэчлэн баталсан. “Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах”, “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд” хөтөлбөрүүдийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжаар батлуулсан. Төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулсан, эрүүл мэндийн сургалт, сурталчилгааг 829 удаа хийж, даохардсан тоогоор 50,2 мянган хүнийг хамруулсан. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцыг 12 суманд шалгасан. Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажилд төсвийн болон ДЭМБ, АХБ, НҮБ, ХДХВ/ДОХ, сүрьеэгийн Глобаль сан зэрэг гадаад, дотоодын хандивлагч байгууллагууд, төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг авч, үйл ажиллагаагаа уялдуулж ажиллаж байна.	70
2	1.1.1.3 ДЭМБ-ын удирдамжийн дагуу эрүүл хот, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	2009-2010	ДЭМБ-ын удирдамж, Эрүүл мэндийн сайдын 176 дугаар тушаалын дагуу “Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын болзлыг шинэчлэн боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. 2009 онд аймгийн Засаг даргын 460 дугаар захирамжаар эрүүл мэндийг дэмжигч байгууллага, гэр бүл, иргэн, сургуулийн ангийг шалгаруулсан.	50
3	1.1.4.1 Төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үнэ төлбөргүй авах эрхийн бичиг олгох үр дүнтэй механизмыг судалж шийдвэрлэнэ	2008-2012	2009, 2010 онуудад аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Явуулын амбулатори”-ийг 14 суманд ажиллуулж, иргэдийг үнэ төлбөргүй үзлэг, шинжилгээнд хамруулж, зохих шатлалын эмнэлгүүдэд эмчлэх, сувилуулах ажлыг хийж ирсэн. Солонгос улсын нарийн мэргэжлийн 50 гаруй эмч, мэргэжилтэн, сайн дурын ажилтан 2009 оны 7 дугаар сард Сайншанд суманд ажиллаж, 2400 хүнд үзлэг хийж, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэн, 18 хүнд хагалгаа хийсэн байна. Мөн Япон улсын нарийн мэргэжлийн эмч нар тус аймагт 2009 оны 9 дүгээр сард ирж 0-15 насны хүүхдүүдэд үзлэг, оношлогоо хийж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлжээ. Эрүүл мэндийн байгууллагууд сар бүр	70

			“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулж, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, түр оршин суугч болон харьяалалгүй, эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулж байна.	
4	1.1.5.1 Эрүүл мэндийн салбарын эрх зүй, санхүүгийн зохицуулалтын механизмыг боловсронгуй болгоно	2008-2012	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ, үйлчилгээний чанарыг харгалзан төсвөөс зарим зардлыг санхүүжүүлэх эхлэл тавигдсан. Аймгийн Засаг даргын 2009 оны 7 дугаар захирамжийн дагуу улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Ачлал” “Идэр-Өлзийт” эмнэлгүүд 2010 онд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах эрхтэй болсон юм.	50
5	1.1.5.2 Эрүүл мэндийн салбарын төрийн байгууллага болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх оновчтой механизмыг бүрдүүлнэ.	2008-2012	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны а/480 дугаар захирамжаар “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын талаар орон нутагт баримтлах бодлого, журам”-ыг баталсан юм.	50
6	1.1.6.3 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг шинэчилнэ	2008-2012	Төр, засгийн гаргах шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
7	1.1.7.5. 5-6 сумын дунд явуулын амбулаторийн үйлчилгээг бий болгож, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангана	2008-2012	Явуулын амбулаторийг 14 суманд ажиллуулж, 2009 онд 14,7 мянга, 2010 онд 23.8 мянган хүнийг үзлэг, шинжилгээнд хамруулсан. Нийтдээ 1870 өвчлөл илрүүлж, 269 хүнийг дээд шатлалын эмнэлэгт, 1650 хүнийг сумын эмчийн хяналтанд өгсөн байна. Мөн бэлгийн замаар дамжих өвчлөлийн 48 тохиолдол илрүүлж, үнэ төлбөргүй эмчилгээнд хамруулжээ. Явуулын амбулатори ажиллах явцад иргэдийн 86,7 хувь нь хамрагдсан, харин хамрагдсан иргэдийн 26,8 хувь нь ямар нэг өвчин эмгэгтэй байсан ажээ. ЭМЯ-наас явуулын амбулаторийн тусламж үйлчилгээнд зориулж фургон автомашиныг аймгийн Нэгдсэн эмнэлэгт олгосон.	70
8	1.1.7.6 Өрх, сумын эмнэлэг бүрийг нэн шаардлагатай багцад заасан эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амд бүрэн үзүүлэх чадавхитай болгох, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг түлхүү хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2008-2012	“Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Улаанбадрах, Хатанбулаг сумдын эмнэлэгт засвар, тохижилтын ажил, хийсэн, Сайншанд, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах сумдын хүн эмнэлгийн барилгын засвар, тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, амрах байрны тохижилт зэрэг нийтдээ 103.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тус аймагт ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа Франц улсын Арева групп аймгийн Нэгдсэн эмнэлэгт 690,0 мянган долларын өртөг бүхий тархины цахилгаан бичлэгийн аппарат, мөн НҮБ-ын “Глобаль сан” 3.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн. 2010 онд улс, орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөрийн 301,2 сая төгрөгийн хөрөнгөөр эмнэлгүүдэд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж нийлүүлсэн. Дээрхи арга хэмжээнүүдийн үр дүнд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалт сумдын эмнэлэгт 81.5 хувь, Нэгдсэн эмнэлэгт 95.2 хувь болсон байна.	70
9	1.1.7.7. Сумын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн стандартыг боловсруулан мөрдөж, нөхцлийг сайжруулна	2008-2012	Сумдын эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг нийт сумдад авч хэрэгжүүлж ирсэн. Улсын төсвийн 228,9 сая, орон нутгийн төсвийн 6,5 сая, “Тогтвортой амьжиргаа” төсөл, хандив	50

			тусламжийн 65,8 сая, бүгд 301,2 сая төгрөгийн хөрөнгөөр эмнэлгүүдэд нэн шаардлагатай багаж, тоног төхөөрөмж нийлүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн.	
10	1.1.7.8. Багийн бага эмчийг бэлтгэж, унаатай болгоно	2008-2012	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн мэдээллийн санг бий болгож, эмч, мэргэжилтнүүдийн тухай мэдээллийг оруулж байгаа. Сум, өрхийн эмнэлгүүд их эмч, сувилагчаар бүрэн хангагдсан. Бага эмч нарын 86,0 хувь, эх баригч нарын 92,3 хувь нь зохих шаардлага хангасан мэргэжлийн хүмүүс байгаа. Улсын төсөв болон □Тогтвортой амьжиргаа□ төслийн хөрөнгөөр Улаанбадрах, Мандах, Дэлгэрэх сумдын багийн эмчид мотоцикль олгосон.	50
11	1.1.9.1 Шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчнийг лабораторийн шинжилгээнд үндэслэн тандах тогтолцоог үндэсний түвшинд бэхжүүлэх арга хэмжээ авна	2008-2012	Томуугийн цар тахлын үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг шинэчилж, ОБЕГ, ЭМЯ, ХӨСҮТ-ийн үнэлгээгээр тус аймаг улс, аймгуудын дунджаас дээгүүр буюу 1.5 оноо аваад байна. Томуугийн А хүрээний H1N1 вирусын халдварын эмчилгээ, үйлчилгээнд зориулсан 16,4 сая төгрөгийн эм, хамгаалах хэрэгслийг ЭМБ-уудад хуваарилан олгов. Төрийн болон хувийн хэвшлийн 5 эмнэлэгтэй гэрээ байгуулан, нийт 110 ор дэлгэх боломжийг бүрдүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 187, 413 дугаар захирамжуудаар орон нутгийн төсвөөс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 1,2 сая, Замын-Үүдийн нэгдсэн эмнэлэгт 1,5 сая төгрөгийн хөрөнгө олгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэв.	70
12	1.1.9.4. “Халдварт өвчинтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, шинэчлэн боловсруулна	2008-2012	Эмнэлгээс шалтгаалсан халдварт өвчин, дархлаажуулалт бүхий халдварт өвчин 2009, 2010 онд гараагүй. 2009 оны 9 дүгээр сараас улаан бурхан-улаанууд-гахайн хавдрын вакциныг дархлаажуулалтад шинээр нэвтрүүлсэн. 0-1 насны хүүхдэд заавал хийх өргөн дархлаажуулалтын хамралт 98.5 хувьтай байна. Орон нутгийн төсвөөс аймгийн Нэгдсэн эмнэлэгт 5.0 сая, Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлэгт 1,5 сая төг-ийн хөрөнгө шийдвэрлэж, томуу болон шинэ, дахин сэргэж буй халдварт өвчний үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангахад дэмжлэг үзүүлэв. Сумдын эмнэлгүүдэд нийтдээ 3.5 сая төг-ийн хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодис, вирусын эсрэг бэлдмэлийг нийлүүлэв. Глобал сангийн ДОХ, Сүрьеэгийн төслийн дэмжлэгтэйгээр “Сорьц тээвэрлэх тогтолцоог бэхжүүлж, сумдын эмнэлгийн лабораторийн чадавхийг сайжруулах” дэд төслийн хүрээнд 5 суманд сорьц тээвэрлэх, хадгалахад зориулсан хөргөгч олгов. Халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг 2010 онд 202 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 12.0 мянган хүнийг хамруулаад байна.	70
13	1.1.11.2. Алсын зайн оношлогооны сүлжээг өргөжүүлж, бүх аймгийн нэгдсэн эмнэлгийг хамруулна	2011-2012	Аймгийн нэгдсэн эмнэлэгт Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Эх, нярайн тусламжинд зайн оношлогооны дэмжлэг үзүүлэх” төсөл хэрэгжиж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр 100 хувь хангасан. Энэ төслийн зардлаар 2 их эмч Тайваньд, 1 их эмч Сингапурт мэргэжил дээшлүүллээ. Эх, нярайн зайн оношлогооны кабинет тайлант хугацаанд 3300 хүнд, зүрх судасны оношлогооны кабинет 465 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Зайн оношлогооны кабинетууд 13	50

			өвчтөний мэдээллийг 3 дахь шатлалын эмнэлэг рүү дамжуулж, 3 хүнийг мэс заслын тусламжинд хамруулсан байна.	
14	1.1.13.2 Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх төрөх, хүүхдийн тасгийн тоног төхөөрөмжийг сайжруулж, шаардлагатай тохиолдолд төрөх газар болон хүүхдийн эмнэлгийг шинээр барьж, перинатологийн төв байгуулна.	2008-2012	Нярайн сэхээн амьдруулах тасагт 0,6 сая, сум, өрхийн эмнэлэгүүдэд эх, нярайн тусламжийн 2,1 сая төгрөгийн эм, хэрэгслийг □Нөхөн үржихүйн эрүүл мэнд□ хөтөлбөрийн хөрөнгөөр олгосон. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр □Эх, нярайн тусламжинд зайн оношлогооны дэмжлэг үзүүлэх нь□ төсөл хэрэгжиж байна. □Хүүхдийн өвчний цогц менежмент□ хөтөлбөр /цаашид ХӨЦМ гэх/-ийг хэрэгжүүлж, эх, нялахаст үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулснаар амьсгалын замын цочмог халдвар, суулгалт өвчнөөр нас баралт буурч, нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 93,3 хувь болсон байна. Аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн захиргаа сум, өрхийн эмч нарыг Нэгдсэн эмнэлгийн төрөх болон хүүхдийн тасаг дээр дадлагажуулах сургалтанд хамруулсан, олон улсын төрийн бус байгууллагын туслалцаатайгаар □Нярайн анхлагч сэхээн амьдруулалт□ сэдэвт сургалт зохион байгуулсан, сургууль, цэцэрлэгийн багш нарт сургалт явуулж, хүүхдүүдэд үзлэг шинжилгээ хийсэн, зарим төрлийн судалгаа авсан, нарийн мэргэжлийн эмч нарыг зайн оношлогоо, нярайн тандалтын чиглэлээр мэргэшүүлсэн зэрэг үр дүнтэй үйл ажиллагаа зохион байгуулсан болно.	50
15	1.1.19.1. Биеийн тамир спортын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж, биеийн тамир спортыг хөгжүүлэх эрх зүйн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	2008-2012	“Нийтийн биеийн тамир, спортын талаар авах арга хэмжээний тухай”, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 41 дүгээр захирамж гаргаж, “Биеийн тамир-эрүүл мэнд” уриан дор сар бүр тодорхой арга хэмжээ зохион байгуулж ирсэн. Уг төлөвлөгөөний дагуу аймгийн ЗДТГ-ын хэлтэс, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд хуваарьт сардаа биеийн тамир, спортын нэгээс доошгүй арга хэмжээг хариуцаж зохион байгуулж ирсэн. Харин санхүүжилтийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал нь төр, засгийн түвшний асуудал бөгөөд энэ талаар гарсан шийдвэрийг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллах болно.	70
16	1.1.19.2 Биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах мэдээлэл, сурталчилгааны ажлыг нэгдмэл байдлаар зохион байгуулна.	2008-2012	2010 онд спортын заалны үйлчилгээний цагийг уртасгаж, 7.00-9.00 цагт биеийн тамир спортоор хичээллэгсэд, сонирхогчид, 9.00-18.00 цагт секц дугуйлан, уралдаан тэмцээн, 19.00-21.00 цагт албан байгууллагуудын чөлөөт цаг гэсэн цагийн хуваарь тогтоосон юм. Ингэснээр биеийн тамир спортоор хичээллэгсдийн тоо өмнөх оныхоос 10.0 гаруй хувиар нэмэгджээ. 2010 онд 67 удаагийн нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж, 6900 гаруй хүнийг хамруулсан. Биеийн тамир, спортоор хичээллэхийн ач холбогдлыг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр байнга сурталчилж байгаа болно.	70
17	1.1.19.3 Нийтийн биеийн тамир, спортын байгууллагын барилга, байгууламжийн засвар, үйлчилгээ, ашиглалтыг үе шаттай	2008-2012	Аймгийн биеийн тамир, спортын газрын барилгын их засварыг улсын төсвийн 45,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Немон” ХХК гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн, төв цэнгэлдэх хүрээлэнд гүйлтийн зам байгуулахад 18.9 сая, цэнгэлдэх хүрээлэнг зүлэгжүүлэх,	50

	сайжруулна		цахилгааны шугамын засвар хийхэд 5,6 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Сайншанд сумын III дунд сургуулийн спортын заалны барилгыг ашиглалтанд хүлээж авсан. “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Мандах, Хөвсгөл, Замын-Үүд, Дэлгэрэх сумын сургуулийн спорт заал, биеийн тамирын талбайг тохижуулсан.	
18	1.1.20.3 Хяналт шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, нотолгоог ХДХВ/БЗДХ-ын эсрэг авах арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана	2008-2012	Глобаль сангийн ДОХ/Сүрьеэгийн төслийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Сорьц тээвэрлэх тогтолцоог өргөжүүлж, сумдын эмнэлгийн лабораторийн чадавхийг сайжруулах” төсөл, ЭМЯ, Глобаль сангийн ДОХ/Сүрьеэгийн төслийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “ХДХВ/БЗДХ-ыг эрт илрүүлэх, эмчлэх нэг цэгийн үйлчилгээ” төсөл, АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “ХДХВ/ДОХ ба хүн худалдахаас сэргийлэх” төсөл зэрэг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт, зөвлөмжийг дараагийн шатны шийдвэр гаргахад ашиглаж байна.	70
<b>.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны бодлого</b>				
19	1.2.2.1 Баг бүрт гэр цэцэрлэг байгуулж, хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжин, СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлнэ	2009-2012	<b>Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа <input type="checkbox"/>Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл<input type="checkbox"/> төслийн 40,2 сая төгрөгийн хөрөнгөөр 6 суманд гэр цэцэрлэг, тавилга, тоног төхөөрөмжийн хамт нийлүүлсэн. <input type="checkbox"/>Тогтвортой амьжиргаа<input type="checkbox"/> төслийн 7,9 сая төгрөгийн хөрөнгөөр Алтанширээ, Даланжаргалан сумдад гэр цэцэрлэг нийлүүлсэн. Өргөн суманд орон нутгийн төсвөөс 4,6 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэж гэр цэцэрлэг ажиллууллаа. Хүүхдийн цэцэрлэгт явдаггүй хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах зорилгоор 2010 онд ээлжийн бүлэгт 161, нүүдлийн гэр цэцэрлэгт 327, явуулын багшийн сургалтанд 68, нийт 556 хүүхдийг хамруулсан байна. Ингэснээр СӨБ-ын хамран сургалт 69,7 хувь болж, өмнөх оныхоос 7,7 хувиар нэмэгджээ.</b> Айраг суманд 4.1 сая, Дэлгэрэх суманд 7.0 сая, Сайншанд суманд 7,7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг шинэчилсэн. “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Сайншанд сумын 1, 5, 6 дугаар цэцэрлэг, Замын-Үүд, Айраг, Дэлгэрэх, Сайхандулаан сумын хүүхдийн цэцэрлэгийн тоглоом наадгай, гадна тохижилт, тоглоомын талбай байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэлээ. Сайншанд суманд шинээр ашиглалтанд орсон IX цэцэрлэгийн дотоод тавилга, тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар 2010 онд 12,3 сая төгрөгийн хөрөнгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэв.	70
20	1.2.2.2. Өмчийн хэлбэрийг үл харгалзан цэцэрлэгийн нэг хүүхдэд оногдох нормативт зардлыг олгоно	2008-2012	Төр, засгийн гаргах шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
21	1.2.2.4 Цэцэрлэгийг тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ	2010-2012	Италийн АИФО байгууллагын “Тэгш дүүрэн,, төсөл Сайншанд сумын 1-р цэцэрлэгт 967,0 мянга, “Тогтвортой амьжиргаа-II” төсөл Сайншанд, Даланжаргалан, Алтанширээ, Дэлгэрэх, Айраг сумын цэцэрлэгүүдэд 3,4-4,1 сая, Зүүнбаянд үйл ажиллагаа явуулж байгаа ”Коже говь” ХХК Зүүнбаянгийн хүүхдийн цэцэрлэгт 3,8 сая, Хамарын хийдийн гэр цэцэрлэгт 3,4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хүүхдийн тоглоом наадгай нийлүүлээд байна.	70

22	1.2.2.5 Цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлнэ	2009-2012	Сайншанд сумын “Саруул дэнж” хороололд 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 2010 онд ашиглалтанд хүлээж авсан, Замын-Үүд суманд 2008 оноос эхлэн баригдаж байгаа 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын хөрөнгө 2009 онд шийдвэрлэгдээгүйгээс түр зогссон, 2010 онд улсын төсвөөс 350,0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, ажил графикийн дагуу явагдаж байна. Замын-Үүд сумын хүүхдийн цэцэрлэг, Сайншанд сумын хүүхдийн I, II, III цэцэрлэгийн барилгын их засварыг салбарын болон төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр шийдвэрлэсэн.	50
23	1.2.3.5 Бага боловсролын хамран сургалтыг 95,0 хувьд хүргэнэ	2009-2012	Бага ангиудаас завсардалт гаргахгүй байх бодлогыг хэрэгжүүлснээр бага боловсролын хамран сургалт 95,0 хувьд хүрээд байна.	90
24	1.2.4.5. Багшийн мэргэжлийн үнэлэмж, нэр хүндийг дээшлүүлж, багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны цалин, хангамжийг нэмэгдүүлнэ	2009-2012	2010 онд Монгол улсын Засгийн газрын 239 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоосон. Энэ шийдвэрийг боловсролын салбарт нэгэн адил хэрэгжүүлж ажиллаж байгаа.	50
25	1.2.4.6. Багш ажилтнууд сургууль дээрээ мэргэжил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд шаардлагатай стандартыг боловсруулж, төрийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө, ажлын байрыг стандартын дагуу тоноглоно	2009-2012	“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд БСГ-аас СӨБ, удирдах ажилтан, ЕБС-ийн багш, АББ-ын гэсэн чиглэлүүдээр олон удаагийн сургалт зохион байгуулсан ба тайлант хугацаанд давхардсан тоогоор 4024 багш, удирдах ажилтан ямар нэг сургалтанд хамрагдсан байна. Үүний дотор БСШУЯамнаас зохион байгуулсан төвлөрсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт 45 багш хамрагджээ. Боловсролын зэргээ ахиулсан удирдах ажилтан 3, багш 6, мэргэжлийн зэргээ ахиулсан удирдах ажилтан 2, багш 63 байна. Багш нарын мэргэжлийг дээшлүүлэхэд интернетийн сүлжээ ашиглах боломжийг дээшлүүлж, одоогоор 8 сургууль интернетэд холбогдоод байна. Сайншанд сумын 1, 3 дугаар сургууль, Замын-Үүд сумын сургуульд боловсролын салбарт хэрэгжиж байгаа төслийн хөрөнгө оруулалтаар “Багшийн хөгжлийн төв” байгуулсан.	70
26	1.2.5.1 Хүн амын бичиг үсгийн тайлагдалтын түвшнийг дээшлүүлнэ	2009-2012	Иргэдийн бичиг үсгийн боловсрол олгох сургалтад 203 хүн хамрагдаж, 86 иргэн бичиг үсэгт тайлагдлаа. Сумдын „Гэгээрэл,, төвүүдэд боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх сургалтад 73, амьдрах ухаан, хөдөлмөрийн дадал олгох сургалтанд 715, мэдээлэл харилцаааны технологи ашиглах сургалтад 111, гадаад хэл судлан эзэмших сургалтад 152 хүн, бусад сургалтад 140 хүн тус тус хамрагдсан байна.	70
27	1.2.5.2 ЕБС-аас завсардсан хүүхдүүдэд албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгоно	2009-2012	Сургууль завсардагчдыг дүйцсэн боловсролын сургалтанд хамруулж, ном сурах бичиг, хичээлийн хэрэгслээр хангах ажлыг Албан бус боловсролын зайны сургалтын үндэсний төвийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байна. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 212 хүүхэд хамрагдаж, 31 хүүхэд, залуучууд суурь боловсрол эзэмшжээ.	90
28	1.2.6.3. Төрөөс ЕБС-ийн сурагчдыг сурах бичгээр хангах график төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна	2009-1012	ЕБС-ийн сурагчдын сурах бичгийг татан авах, сургуулиудад хуваарилах, сурах бичгийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг заавар, журмын хэрэгжүүлж байна.	50
29	1.2.7.1 “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж сургуулийн хоолны газар, дотуур байрны гал тогоог	2009-2012	Аймгийн хэмжээнд 1-5 дугаар ангийн 5998 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл болгож Боловсролын салбарын болон төслийн хөрөнгө оруулалтаар Айраг, Эрдэнэ, Сайншандын I, II дунд сургуульд	

	зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана		тус бүрт нь 25,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж олгосныг зохих шаардлага хангасан байранд суурилуулж, ашиглаж байна. “Тогтвортой амьжиргаа-II” төслийн хөрөнгөөр Даланжаргалан, Сайхандулаан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Хөвсгөл, Улаанбадрах сумдын, аймгийн орон нутгийн төсвийн 1,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны гал тогоонд тоног төхөөрөмж нийлүүлж, “Үдийн хоол” “Үдийн цай” хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүллээ.	50
30	1.2.7.2. “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам баглан мөрдүүлж, сурагчдыг хөтөлбөрт ээлж дараатай хамруулна.	2010-2012	“Үдийн цай” хөтөлбөрийг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа. “Өдрийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл болгож Боловсролын салбарын болон төслийн хөрөнгө оруулалтаар Айраг, Эрдэнэ, Сайншандын I, II дунд сургуульд тус бүрт нь 25,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гал тогооны цахилгаан тоног төхөөрөмж олгосныг зохих шаардлага хангасан байранд суурилуулж, ашиглаж байна	50
31	1.2.9.1 ЕБС-ийг 3 дугаар ээлжгүй болгоход чиглэсэн арга хэмжээ авна	2009-2012	ЕБС-ийг 3 дугаар ээлжгүй болгох хэрэгцээ Сайншанд, Замын-Үүд сумдад улам бүр нэмэгдэж байна. Сайншанд суманд 960 хүүхдийн хичээлийн байрны барилгад 2010 онд 240.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн, барилгын ажил 30.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Тус сумын “Саруул дэнж” хороололд 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтанд хүлээж авсан, 2010 оны 10 дугаар сарын 1-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж байна. Замын-Үүд суманд 2008 оноос эхлэн баригдаж байгаа 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын хөрөнгө 2009 онд шийдвэрлэгдээгүйгээс түр зогссон, 2010 онд улсын төсвөөс 350,0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, ажил графикайн дагуу явагдаж байна.	50
32	1.2.9.3 Ангийн самбар, багш, сурагчийн ширээ, сандлыг ээлж дараатай шинэчилнэ	2009-2012	“Боловсролын салбарын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн 9,4 сая төгрөгийн хөрөнгөөр Зүүнбаянгийн сургуульд, 1,8 сая төгрөгийн хөрөнгөөр Сайншанд сумын 3-р сургуульд, “Тогтвортой амьжиргаа-2” төслийн 7,6 сая төгрөгийн хөрөнгөөр Замын үүд сумын сургуулийн зарим ангийн ширээ сандлыг шинэчилсэн.	70
33	1.2.9.4 Дотуур байр барьж, өргөтгөн орчны ариун цэвэр, усны хангамжийг сайжруулна	2009-2012	Өргөн сумын дотуур байрны шинэ барилгыг 2009 онд ашиглалтанд хүлээж авсан, „Боловсролын хөгжлийн хөтөлбөр,-ийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны засвар, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн 212.9 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэ сумын сургуулийн дотуур байрны их засварыг хийсэн.	70
34	1.2.10.1 Зарим аймгийн төвд усан бассейн байгуулж, хүүхэд залуучуудын биеийн тамир, спортоор хичээллэх орчин бүрдүүлнэ	2010-2012	Сайншанд суманд 2004 онд байгуулсан усан бассейн шаардлага хангаж ажиллаж байгаа	90
35	1.2.12.2 Хөдөлмөрийн зах зээлийн судалгааг сайжруулж, эрэлт, нийлүүлэлтэнд тохирсон мэргэжилтэй ажилтан бэлтгэх төлөвлөлтийг сайжруулна	2009-2012	Ажил олгогчийн захиалга болон иргэдийн хүсэлтийг харгалзан 23 удаагийн сургалт зохион байгуулж, 420 иргэнийг хамруулан, 42,6 сая төгрөгийн хөрөнгийг ХЭДСангаас зарцуулсан байна. Олон улсын шаардлагад нийцсэн мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох ур чадварын сургалтыг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 5 удаа зохион байгуулж 89 хүнийг үнэмлэхжүүлсэн. Зам барилга, уул уурхайн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 100 залуучуудыг төмөр замын ажилчин бэлтгэх	



			<p>сургалтанд хамруулж төгсгөлөө.</p> <p>“Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 212 дугаар тогтоолын дагуу ажилгүй иргэдийг уул уурхай, зам тээврийн шинэ бүтээн байгуулалтанд оролцуулахад шаардагдах мэргэжил олгох сургалтуудыг МСҮТ-үүдийг түшиглүүлэн зохион байгуулж эхлээд байна. Аймгийн МСҮТ-д Мянганы хөгжлийн сорилтын сангаас 39,0 мянган ам.долларын төсөл хэрэгжиж, уул уурхайн чиглэлээр 4 анги шинээр нээж, сургалт, дадлагын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаад байгаа юм.</p> <p>Аймгийн МСҮТ, Говьсүмбэр аймгийн МСҮТ, Улаанбаатар хотын “Арука”, “Футур” сургалтын төвүүдтэй хамтран тогооч, үсчин гоо засал, автозасварчин, гагнуурчин, асаргаа сувилгаа, цэцэрлэгийн туслах багш зэрэг 13 төрлийн мэргэжлээр 17 удаагийн сургалт зохион байгуулж 401 иргэнийг суралцуулж чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгоод байна. Сургалтын зардал болон хоол унааны зардалд 31,3 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа.</p>	70
36	1.2.14.3 Дотоодын их, дээд сургуульд зохих журмын дагуу элсэж, сумын ИТХ, Засаг даргын захиалгаар гэрээ байгуулсан оюутны сургалтын төлбөрийг төрөөс хариуцна	2009-2012	Төрийн албаны хуулийн дагуу төрийн ажилтны 1 хүүхдийн сургалтын зардлыг төрөөс хариуцаж байгаагаас өөр төрөөс сургалтын төлбөрийг хариуцаж байгаа тохиолдол байхгүй. Харин төсвийн бус эх үүсвэрээр бүрдүүлдэг “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас аймагт нэн шаардлагатай мэргэжлээр дотоодод сурч байгаа 19 оюутны сургалтын төлбөрт 18,7 сая төгрөг, гадаад оронд сурч байгаа 2 оюутны сургалтын төлбөрт 2,5 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	50
37	1.2.20.1. Их дээд сургууль, мэргэжлийн төрөлжсөн сургууль, тэдгээрийн салбарыг бүсийн төв болон орон нутгийн хотод байгуулахыг дэмжинэ.	2010-2012	Дорноговь аймагт үйл ажиллагаа явуулж байсан Анагаах ухааны коллежийг 2010 онд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн салбар сургууль болгож өргөтгөсөн. Төмөр замын МСҮТ-ийг тус аймагт аймагт байгуулах санал дэмжигдэж, байрны асуудлыг шийдвэрлээд байгаа, 2011 оноос сургалтыг үйл ажиллагаагаа эхлэхээр бэлтгэж байна. Аймгийн МСҮТ-д хүнд машин механизмын жолооч, операторчин бэлтгэх ангийг шинээр нээсэн. Мөн Оюу толгойн захиалгаар мэргэжилтэй ажилчин бэлтгэх ангиудыг нээж эхний ээлжинд 80 суралцагч хүлээн аваад байна.	50
38	1.2.25.1 Соёлын төвийн барилгыг шинээр барих, засварлах ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ	2009-2012	<p>“Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Айраг, Мандах, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын соёлын төвүүдэд нийтдээ 65.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, их засвар, тохижилтын ажлыг хийсэн, улсын төсвийн хөрөнгөөр Даланжаргалан сумын соёлын төвийн засвар, тохижилтын ажлыг хийсэн байна.</p> <p>“Саран хөхөө” театрын барилгын өргөтгөл, шинэчлэлтийг РЭМУГС ХХК гүйцэтгэж, 2010 оны 6 дугаар сард ашиглалтанд хүлээлгэж өгсөн.</p> <p>Сайншанд суманд Ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн ордны барилгыг 2010 оны 7 дугаар сараас “Сондуулт Эг” ХХК улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн. Барилгын суурийн ажил дуусч, ханын өрөг угсралтын ажил хийгдэж байна.</p>	50
39	1.2.25.3 Алслагдсан нутгийн хүн амыг мэдээллээр хангах хүрээ хүртээмжийг нэмэгдүүлж, “Явуулын номын сан”-гийн үйлчилгээг нэвтрүүлнэ	2008-2012	Аймгийн төв номын санд БСШУЯ-аас 2009 онд 2 сая төгрөгийн номын фондын баяжилт хийсэн, „Коже говь,, ХХК-ын 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар компьютер, техник, тоног төхөөрөмжөөр хангасан, мөн аймгийн орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэж, зарим өрөө тасалгааны их засварыг хийж,	

			интернетийн сүлжээнд холбосон. Дэлхийн сонгодог зохиолын 50 боть, 2010 оны шилдэг ном, зохиолуудын багцыг 2010 онд БСШУЯ-аас хуваарилсныг сумдын болон ЕБС-ийн номын сангуудад олгосон. 2010 онд хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн 65,2 сая төгрөгийн 10,0 мянган ш ном, 48,5 сая төгрөгийн 24,4 мянган ш сурах бичгээр фондын баяжилт хийсэн. Номын сангуудыг иргэдийн мэдээллийн үйлчилгээний төв болгох бодлогыг хөдөөгийн иргэдэд явуулын үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ авч байна.	70
40	1.2.28.3 Үндэсний түүх, соёлоо дээдэлж, “Монгол бичиг”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол бий, биелгээ”, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	2008-2012	“Монгол бичиг”, “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол бий, биелгээ”, “Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж ирсэн. Аймгийн орон нутгийн төсвөөс 1,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн нутаг дэвсгэрт байгаа түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг сурвалжлах, бүртгэл, хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулав. Аймгийн Музей сургалт судалгааны төв 2,7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, түүхт хүмүүсийн хэрэглэж байсан эд өлгийн зүйлээр сангаа баяжуулжээ.	50
<b>1.3. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн бодлого</b>				
41	1.3.1.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг аж ахуйн нэгж, иргэдийн санаачлагад тулгуурлан орон нутаг, бүс, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ	2009-2012 НХХЯ	2010 онд аймгийн хэмжээнд 1293 ажлын байр шинээр нээгдсэн нь өмнөх жилд нээгдсэн ажлын байрнаас 23,9 хувиар илүү байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 171,5 сая төгрөгийн зээлийг 156 иргэнд, иргэдийн үүсгэл санаачлагын оролцоонд түшиглэсэн 27 бүлгийн 180 иргэнд 18,0 сая төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сангаас олгосон нь үр дүнгээ өгч, дээрхи арга хэмжээний үр дүнд 162 ажлын байр шинээр нээгджээ. Харин Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн ажилгүйчүүд 656 буюу өмнөх оныхоос 19 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь шинээр ажилгүйчүүдийн эгнээнд шилжих үзэгдлээс биш, ажилгүй байсан иргэд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад хандах хандлага нэмэгдсэнээс үүдэлтэй гэж үзэж байна. Тус аймагт ажилгүйдлийн түвшин 3,4 буюу улсын дунджаас 8,3 хувиар бага байгаа юм. Нийтийг хамарсан төсөлт болон цагийн ажилд хөдөлмөр эрхлээгүй 605 иргэнийг хамруулж ажлын хөлсөнд 50,8 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгожээ. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих томоохон арга хэмжээний нэг нь Төмөр замын Сайншанд өртөөний сургалтын баазыг түшиглүүлэн ажилгүй 100 залууг мэргэжлийн сургалтанд хамруулж төгсгөсөн, Оюу толгойн зардлаар 80 ажилчин бэлтгэх сургалтыг эхэлсэн явдал болно.	70
42	1.3.6.2. “Нэг өрх-нэгээс доошгүй ажлын байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012	Шинээр нээгдсэн ажлын байранд өрх бүрээс нэг хүн ажилд орсон гэж үзвэл 2010 онд 1293 өрхийн нэг иргэн ажилтай болжээ. Харин ам бүлд нь тогтвортой орлоготой ажил, үйлчилгээ эрхэлдэг хүнгүй айл өрхийн судалгаа одоогоор гараагүй байна.	50
43	1.3.7.1 Эрэлтэд тулгуурласан “Эрхийн бичиг”-ийн сургалтыг орон нутагт өргөжүүлнэ./МСҮТ-д/	2009-2012 НХХЯ	“Зам барилга уул уурхайн салбарт мэргэжилтэй ажилтан бэлтгэх, үйлдвэрлэл дээрх сургалын дэд хөтөлбөр,-ийн хүрээнд 100 ажилгүй иргэнийг Төмөр замын замчин мэргэжлээр мэргэшүүлэн сургаж төгсгөлөө. “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 212 дугаар тогтоолын дагуу ажилгүй иргэдийг уул уурхай, зам тээврийн шинэ бүтээн байгуулалтанд оролцуулахад шаардагдах мэргэжил олгох сургалтуудыг МСҮТ-үүдийг түшиглүүлэн зохион байгуулж эхлээд байна.	50

			Аймгийн МСҮТ-д Мянганы хөгжлийн сорилтын сангаас 39,0 мянган ам.долларын төсөл хэрэгжиж, уул уурхайн чиглэлээр 4 анги шинээр нээж, сургалт, дадлагын орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангасан. Аймгийн МСҮТ, Говьсүмбэр аймгийн МСҮТ, Улаанбаатар хотын “Арука”, “Футур” сургалтын төвүүдтэй хамтран тогооч, үсчин гоо засал, автосасварчин, гагнуурчин, асаргаа сувилгаа, цэцэрлэгийн туслах багш зэрэг 13 төрлийн мэргэжлээр 17 удаагийн сургалт зохион байгуулж 401 иргэнийг суралцуулж чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх олгоод байна. Сургалтын зардал болон хоол унааны зардалд 31,3 сая төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцууллаа. Мөн мэргэжлийн үнэмлэх, зэрэг олгох ур чадварын сургалтыг түгээмэл мэргэжлээр 5 удаа зохион байгуулж, 89 хүнийг үнэмлэхтэй болгов.	
44	1.3.15.1 МСҮТ болон техникийн боловсролын сургуульд суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлнэ	2009-2012 БСШУЯ	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Мэргэжлийн сургуулиудын холбооноос зарласан уралдаанд “Сургалтын шилдэг орчин бүрдүүлэгч” байгууллагаар шалгарсан тус аймгийн МСҮТ-ийн хүчин чадал нэмэгдэж, 2010-2011 оны хичээлийн жилд 12 мэргэжлээр 913 хүүхэд суралцуулж байгаа нь өмнөх оныхоос хүүхдийн тоо 14,7 хувиар нэмэгдсэн үзүүлэлт болно.	70
<b>1.4. Нийгмийн хамгааллын бодлого</b>				
45	1.4.1.1. Нийгмийн ажилтнуудыг мэргэшүүлэх, тэдний ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2009-2012 НХХЯ	Сумдын амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, халамжийн нийгмийн ажилтнуудад 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, гарын авлага материалаар хангасан. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан нийгмийн ажилтнуудыг 4 удаагийн сургалтанд хамрууллаа. Дээрхи сургалтуудаар нийгмийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлах, хүнд суртал, чирэгдэлгүй, шудрага, ил тод, нээлттэй байдлаар ажиллах талаар зөвлөгөө, үүрэг чиглэл өгч байсан.	70
46	1.4.6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээ хүргэдэг байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулж, хүнд суртал, чирэгдэлгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээ авна	2009-2012 НХХЯ	2009 оны 2 дугаар сараас сум бүрт хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан нийгмийн ажилтнуудыг ажиллуулах болсон. Тэднийг хэд хэдэн удаагийн сургалтанд хамруулж, гарын авлага, хуулийн эмхэтгэл, зөөврийн компьютер, принтерээр хангаж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлснээр хүн амд хүргэх нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн.	70
47	1.4.11.2 “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т үндэслэн бүс нутгийн эдийн засаг, дэд бүтцийн хөгжилтэй уялдан арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 НХХЯ	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” одоогоор гараагүй байгаа. Аймгийн хэмжээнд ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд 296 өрхийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллуулж байна. Үүнээс 180 өрх орлогын тогтвортой эх үүсвэртэй болж, амьжиргаа сайжирч байгаа судалгаа гарсан. Аймгийн хэмжээд 8317 иргэн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, эсвэл ямар нэг орлогогүй байгаа нь өмнөх жилийнхээс 12.5 хувиар буурсан үзүүлэлт болно. 2010 онд 1293 ажлын байр шинээр нээгдсэн нь өмнөх оныхоос 12,3 хувиар нэмэгдсэн байна.	50
48	1.4.12.1. Хувийн хэвшил, иргэдийн оролцоо, санаачлагад тулгуурлан “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ	2009-2010	“Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” одоогоор гараагүй байгаагаас орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна	-
49	1.4.12.2. “Өрхийн хөгжлийг дэмжих	2009-2012	Аймгийн хэмжээнд ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн	

	үндэсний хөтөлбөр"-т хамрагдах өрхийг сонгох, өрхийн хөгжлийн төлөвлөгөө гаргах аргачлалыг боловсруулна		хүрээнд 296 өрхийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллуулж байна. Тэдгээр өрхийн хүн амыг халамжийн үйлчилгээнд хамруулах, ажлын байранд зуучлах, мэргэжил олгох сургалтанд хамруулах, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих болон халамжийн сангаас олгодог зээлд хамруулах зэргээр боломжтой арга хэмжээ авч, амьжиргааг нь дэмжиж ажиллаж байна.	50
50	1.4.12.3. Өрхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн тухайн өрхийг хөгжүүлэх, амьжиргааг дээшлүүлэх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоотойгоор зохион байгуулж, хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулна	2009-2012	Өрхийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан өрхийн мэдээллийн сан байгуулсан. Одоогоор 296 өрхийн мэдээллийг уг санд оруулаад байна	50
51	1.4.12.4 Нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн ядууралтай тэмцэх чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ	2009-2010 НХХЯ	<p><b>2009 онд 296 өрх, 2010 онд 297 өрхийг ядуурлаас гаргах бодлого баримталж, хүн ам, өрхийн тоонд харьцуулан ядуурлаас гаргах өрхийн тооны доод хязгаарыг сумдад тогтоож, ядуу өрхийн мэдээллийн сан бүрдүүлэх, өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжил олгох сургалтад хамруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ирлээ.</b></p> <p>Дээрхи өрхүүдэд өрхийн хөгжлийн төлөвлөгөө бүхий дэвтэр хөтлүүлж, ядуурлыг бууруулах чиглэлээр зохиосон ажлыг тэмдэглэж, үр дүнг тооцож байна. Мэргэжил, ур чадвар шаардахгүй, нийтийг хамарсан ажилд дээрх өрхийн 147 иргэнийг хамруулж, 11,4 сая төгрөгийн цалин хөлс олгосон, 52 иргэнийг барилга засал чимэглэл, буриад гутал, цахилгаанчны зэрэг сургалтанд хамруулж, түүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1,5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. 2010 онд 297 өрхөөс 178 өрх буюу 60,0 хувийн нь амьдралд нааштай өөрчлөлт гарсан гэсэн судалгаа байна.</p> <p>Олон малтай айл өрхөд малчнаар ажиллуулах, багийн хөгжлийг дэмжих сангийн хөрөнгөөр мал худалдан авч олгох, байгууллага, иргэдийн хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийг малжуулах үйл ажиллагаанд зарцуулах зэргээр 2009 онд аймгийн хэмжээнд 180 өрхөд 3665, 2010 онд 201 өрхөд 4831 толгой мал олгосон байна. Малжуулах үйл ажиллагаанд хамрагдсан өрхийн тоо 2010 онд өмнөх оныхоос 11.6 хувиар өсчээ.</p> <p>Малжуулах үйл ажиллагаанд 103.9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсны дотор 44.8 хувь нь гадаад дотоодын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, 6.9 хувь нь аймаг, сумын орон нутгийн төсөв, аймаг, сумыг хөгжүүлэх сангийн хөрөнгө, 48.3 хувь нь сум, багийн иргэдийн санаачлага, хандив тусламж, багийн хөгжлийг дэмжих сан зэрэг эх үүсвэрээр шийдвэрлэгдсэн байна.</p> <p>ХААН банк малжуулах зориулалтаар 5,0 хүртэл сая төгрөгийн, 1,25 хувийн хүүтэй зээлийг 1 жилийн хугацаатай олгож байгаа бөгөөд энэ зээлд 2010 онд 23 иргэн хамрагдаж, нийт дүнгээрээ 21,0 сая төгрөгийн зээл аваад байгаа ажээ. 2010 оны эцэст тус аймгийн 2609 өрх, 9865 хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой амьдарч байгаа гэсэн судалгаа гарсан байна. Энэ нь аймгийн нийт өрхийн 15,1 хувь, хүн амын 16,8 хувь болж байгаа юм.</p>	70

52	1.4.15.1. “Хүн байхын учир” аяныг өрнүүлж, хүүхэд, өсвөр үеийнхний “Гэр бүлдээ үүнийг хүснэ” “Миний паспорт” “Миний нэрийн хуудас” зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачлагыг бүх талаар дэмжинэ.	2009-2012	<p>“Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. “Хүүхдийн хүмүүжил төлөвшилд эцэг эхийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг 2010 оны 6 дугаар сард “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулж, 40 эцэг эхийг оролцуулав.</p> <p>Хүүхэд, залуучууд, гэр бүлд зориулсан сургалт, мэдээллийн үйлчилгээг тогтмол явуулж ирлээ. “Хүн байхын учир”, “Гэр бүлдээ үүнийг хүснэ” “Миний паспорт” “Миний нэрийн хуудас” зэрэг хөдөлгөөн, үүсгэл санаачлагыг өргүүлж ажилласан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” төсөл хэрэгжиж байна. ХААН банкны “ХААН банк сан”-гийн 7,0 сая төгрөгийн хөрөнгө, АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хүүхдийн “Танин мэдэхүйн төв”-ийг Сайншанд сумын ЕБ-ын нэгдүгээр сургууль дээр байгуулсан. Монголын Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг орон нутагт зохион байгуулахад дэмжлэг болгож аймгийн орон нутгийн төсвөөс 1,0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэсэн.</p>	90
53	1.4.15.2 Хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч, энэрэнгүй, нийгмийн идэвхтэй болгож хүмүүжүүлэхэд гэр бүл, ТББ-уудтай хамтран ажиллана	2009-2010 НХХЯ	<p>“Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. “Хүүхдийн хүмүүжил төлөвшилд эцэг эхийн үүрэг оролцоо” сэдэвт сургалтыг 2010 оны 6 дугаар сард “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулж, 40 эцэг эхийг оролцуулав.</p> <p>“Сайн эцэг эх”, “Хүүхдийн хүмүүжил”, “Хүүхдийг хэрхэн архи тамхинаас хол байлгах вэ” гэсэн сэдвүүдээр сургалт, ярилцлага, мэтгэлцээн явууллаа.</p> <p>Хүүхэд, залуучууд, гэр бүлд зориулсан сургалт, мэдээллийн үйлчилгээг тогтмол явуулж ирлээ. 2010 онд хүүхдийн эрх, үүрэг, оролцооны чиглэлээр цуврал хичээл явуулж, түүний гарын авлага 7 номыг бэлтгэсэн. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” төсөл хэрэгжиж байна. Мөн АНУ-ын “Мерси кор” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах “Гэгээн ирээдүй” төвийг байгуулсан.</p> <p>ХААН банкны “ХААН банк сан”-гийн 7,0 сая төгрөгийн хөрөнгө, АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хүүхдийн “Танин мэдэхүйн төв”-ийг Сайншанд сумын ЕБ-ын нэгдүгээр сургууль дээр байгуулсан. Монголын Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг орон нутагт зохион байгуулахад дэмжлэг болгож аймгийн орон нутгийн төсвөөс 1,0 сая төгрөгийн хөрөнгийг 2010 онд шийдвэрлэсэн.</p> <p>Монгол улсын төрийн соёрхолт, Ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит өсвөрийн гоцлол бүжигчдийн улсын X наадмыг 2010 онд Улаанбаатар хот болон Сайншанд суманд зохион байгуулж, түүнд орон нутгийн төсвөөс 9,5 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэв.</p>	90
54	1.4.15.3 Хүүхэд, өсвөр үеийг эрүүл амьдралын дадал хэвшилд сургах, хорт зуршлаас татгалзах мэдлэг чадварыг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааг өргөжүүлнэ	2009-2010 ЭМЯ	<p>Аймгийн Хүүхдийн төлөө хэлтсээс Хүүхдийн эрүүл эсэн мэнд амьдрах эрхийг хэргэжүүлэх зорилгоор Аймгийн ЭМГ-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн Цагдаагийн газрын Хүүхдийн байцаагчтай хамтран гэмт хэрэгт холбогдсон 5 хүүхдийг эцэг эхтэй нь хамт хүлээн авч уулзалт ярилцлага зохиолоо.</p> <p>Хүүхэд өсвөр үеийнхнийг бие бялдрыг хөгжүүлэх, орон нутгийн байгаль орчинтой танилцах, хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх зорилгоор хүүхдийн явган аялал, дугуйн аялалыг МСҮТ, ЕБС-ийн 80 сурагчийг хамруулан зохион байгууллаа.</p>	70
1.5. Хүн амын бодлого				

55	1.5.2.2 “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийг зарлана	2010 НХХЯ	Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хүрээнд аймгийн Засаг дарга тус аймагт шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн салбарын нээлтэнд оролцлоо. Тус салбар 2009 оны 10 дугаар сараас үйл ажиллагаа эхэлсэн ба одоогийн байдлаар 50 гаруй гишүүдийг эгнээндээ нэгтгээд байна. Энэ салбар эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй, хүүхэд, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах юм.	50
56	1.5.6.3. Ахмадууд нийгмийн амьдралд идэвхитэй оролцох, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь туслах зорилгоор аймаг бүрт ахмадын ордон барина	2010-2011 НХХЯ	Сайншанд суманд баригдах ёс заншил, хүндэтгэлийн өргөөнд ахмадуудад зориулсан танхим байгуулж, ахмадууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх юм. Нийтдээ 1410,2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй энэ объектийг 927,8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Сондуулт Эг” ХХК тендэрт шалгарсан. 2010 онд улсын төсвийн 400,0 сая төгрөгийн хөрөнгөөр барилгын суурь, зоорийн давхрын дам нуруу, хучилтын ажлыг гүйцэтгээд байгаа юм. Ёс заншил, хүндэтгэлийн өргөөг ашиглалтанд орохоос өмнөх хугацаанд ч Сайншанд сумын ЗДТГ, багийн ажлын байр, Хүүхдийн ордон зэрэг газарт ахмадууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл бололцоо байгаа юм.	50
57	1.5.10.1 Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага, хөдөлгөөн, зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн саналыг бодлого, шийдвэрт тусгах талаар нутгийн захиргааны байгууллагыг зөвлөмжөөр хангана	2009-2010 ХТГ	2010 онд хүүхдийн эрх, үүрэг, оролцооны чиглэлээр цуврал хичээл явуулж, түүний гарын авлага 7 номыг бэлтгэсэн. НҮБ-ийн Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хүүхдэд ээлтэй хууль зүйн орчин” төсөл хэрэгжиж байна. Мөн АНУ-ын “Мерси кор” олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд туслах “Тэгээн ирээдүй” төвийг байгуулсан. ХААН банкны “ХААН банк сан”-гийн 7,0 сая төгрөгийн хөрөнгө, АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хүүхдийн “Танин мэдэхүйн төв”-ийг Сайншанд сумын ЕБ-ын нэгдүгээр сургууль дээр байгуулсан. Монголын Хүүхдийн байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн арга хэмжээг орон нутагт зохион байгуулахад дэмжлэг болгож аймгийн орон нутгийн төсвөөс 1,0 сая төгрөгийн хөрөнгийг 2010 онд шийдвэрлэсэн.	70

*ХОЁР. ҮЙЛДВЭРЖҮҮЛЭЛТИЙН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ,  
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ*

№	Зорилт	Хугацаа	Биелэлтийн явцын тухай тэмдэглэл	хувь
<b>2.1. Макро эдийн засаг, санхүүгийн бодлого</b>				
58	2.1.1.1 Эдийн засгийн салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар өсөлтийг нэмэгдүүлнэ	2009-2012 СЯ	Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоог Сангийн сайд, ҮСГ-ын даргын 2006 оны 129/376 тоот тушаалаар батлагдсан 19 салбар, ангилалын дагуу гаргаж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн оны үнээр 2009 онд 50.5 тэрбум төгрөг болж өмнөх оныхоос 18.8 хувиар, нэг хүнд оногдох ДНБ 875.2 мянган төгрөг болж 12.7 хувиар тус тус өсчээ. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн 7,1 нэгжийг хөдөө аж ахуйн салбар, 2,3 нэгжийг үйлдвэрлэлийн салбар, 9,5 нэгжийг үйлчилгээний салбар тус тус хангасан байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл: 37,4 хувийг хөдөө аж ахуй, 11,5 хувийг тээвэр, агуулахын үйлчилгээ, 3,7 хувийг барилга, 7,7 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, 10,6 хувийг боловсрол, 8,6 хувийг төрийн удирдлага, батлан хамгаалах, 20,5 хувийг бусад салбар эзэлж байна. Салбарын ерөнхий	50

			ангилалаар авч үзвэл үйлдвэрлэлийн салбар 12.4 хувь, үйлчилгээний салбар 50.1 хувь, хөдөө аж ахуйн салбар 37.4 хувийг эзэлж байна. Сайншандад аж үйлдвэрийн парк байгуулахтай холбогдуулан хүнс, мах, сүүний үйлдвэр, газар тариалан, барилгын материалын зэрэг үйлдвэрүүд шинээр байгуулагдах хэрэгцээ үүсч, эдийн засгийн бүтэц сайжрах боломж бүрдэж байна. Шинээр үүсэх жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хуучин үйлдвэрлэлийг өргөтгөх, техник, технологийн шинэчлэлт хийхэд зориулж 2009 онд 56 төсөлд 780,0 сая, 2010 онд 46 төсөлд 653,0 сая төгрөгийн зээл олгоод байна.	
59	2.1.2.1 Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн төлөвлөлт, зохицуулалтыг сайжруулна	2009-2010 СЯ	Үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтуудад тулгуурлан аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулсан. Мөн төвийн бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтын саналуудыг тусгаж, эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүдийг эерэг байлгахууц арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар ажиллаж байна. Өмнөд бүсийн хөгжлийн бодлого, үүний дотор төмөр замын талаар баримтлах төрийн бодлого тодорхой болсноор аймаг өөрийнхөө хөгжлийн бодлогыг шинээр томъёолж байна. “Дорноговь аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, аймгийн ИТХ-ын 2010 оны 6 дугаар хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн болно.	50
60	2.1.2.2 Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, иргэдийн амьдралын түвшнийг дээшлүүлэх үндэсний тооцооны шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгө оруулалтын хэрэгцээг оновчтой тодорхойлж, эдийн засгийн тогтвортой өсөлт, хөгжлийн тэнцвэрийг бататгах, макро эдийн засгийн зохицуулалтын орчныг сайжруулна	2009-2010 СЯ	2010 онд аймгийн хэмжээнд 1293 ажлын байр шинээр нээгдсэн нь өмнөх жилд нээгдсэн ажлын байрнаас 23,9 хувиар илүү байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 171,5 сая төгрөгийн зээлийг 156 иргэнд, иргэдийн үүсгэл санаачлагын оролцоонд түшиглэсэн 27 бүлгийн 180 иргэнд 18,0 сая төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сангаас олгосон нь үр дүнгээ өгч, дээрхи арга хэмжээний үр дүнд 162 ажлын байр шинээр нээгджээ. Харин Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн ажилгүйчүүд 656 буюу өмнөх оныхоос 19 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь шинээр ажилгүйчүүдийн эгнээнд шилжих үзэгдлээс биш, ажилгүй байсан иргэд хөдөлмөр эрхлэлтийн байгууллагуудад хандах хандлага нэмэгдсэнээс үүдэлтэй гэж үзэж байна. Тус аймагт ажилгүйдлийн түвшин 3,4 буюу улсын дунджаас 8,3 хувиар бага байгаа юм. <b>2009 онд 296 өрх, 2010 онд 297 өрхийг ядуурлаас гаргах бодлого баримталж, хүн ам, өрхийн тоонд харьцуулан ядуурлаас гаргах өрхийн тооны доод хязгаарыг сумдад тогтоож, ядуу өрхийн мэдээллийн сан бүрдүүлэх, өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжил олгох сургалтад хамруулах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж ирлээ.</b> <b>2009 онд аймгийн хэмжээнд 180 өрхөд 3665, 2010 онд 201 өрхөд 4831 толгой мал олгосон байна. Малжуулах үйл ажиллагаанд хамрагдсан өрхийн тоо 2010 онд өмнөх оныхоос 11.6 хувиар өсчээ.</b> 2010 оны эцэст тус аймгийн 2609 өрх, 9865 хүн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой амьдарч байгаа гэсэн судалгаа гарсан байна. Энэ нь аймгийн нийт өрхийн 15,1 хувь, хүн амын 16,8 хувь болж байгаа юм.	50
61	2.1.2.6 Улсын төсөв, Монгол улсыг	2009-2012	Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2008-2009 онуудад нийт 9906,1 сая	

	хөгжүүлэх сангийн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв хотуудын зорилтот хөтөлбөр, төсөл, арга хэмжээтэй уялдуулан хуваарилж хэрэгжүүлнэ	СЯ	төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн. “Саран хөхөө” театрын өргөтгөл, ЕБ-ын III сургуулийн спортын заал, Сайншанд сумын “Саруул дэнж” хорооллын 150 хүүхдийн цэцэрлэг, МСҮТ-ийн дадлагын байр, Орон сууцны санхүүжилтийн корпорацийн хөрөнгөөр 20 айлын орон сууц, Хатанбулаг сумын цагдаагийн кобон, Айраг сумын эмнэлгийн моргын барилга, Дэлгэрэх сумын эмнэлгийн эхчүүдийн амрах байр зэрэг барилга, объектууд ашиглалтанд орсон юм. 2010 онд улсын төсвийн 2031,6 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1057,8 сая төгрөг, байгууллагын урсгал төсөвт тусгагдсан 197,7 сая, нийт 3287,1 сая төгрөгийн батлагдсан хөрөнгөөр нийт 41 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Нийт 31 төсөл, арга хэмжээнээс одоогийн байдлаар 26 нь буюу 86,6 хувь нь бүрэн хэрэгжиж хүлээлгэн өгсөн. Хөрөнгө оруулалтын зориулалтаар нь авч үзвэл хөдөө аж ахуйн салбарт 365,1 сая төгрөг буюу 11,1 хувь, байгаль орчны салбарт 158,4 сая төгрөг буюу 4,8 хувь, дэд бүтцийн салбарт 818,0 сая төгрөг буюу 24,9 хувь, бусад салбарт 1945,6 сая төгрөг буюу 59,2 хувь нь хамаарч байна.	50
62	2.1.10.1. Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ	2009-2010 ҮХШХ, СЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
63	2.1.14.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах эрх зүйн баримт бичгүүдийг батлан мөрдүүлнэ	2009-2010 ЭБЭХЯ	Монгол улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” батлагдсан. Уг бодлогын баримт бичигт: Даланзадгад-Таван толгой-Зүүнбаян, Сайншанд-Баруун-Урт - Чойбалсан чиглэлийн төмөр зам тавих, ашигт малтмалын гаралтай түүхий эд боловсруулах “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бодлогыг тусгасан юм. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол гарч, дээрхи бүтээн байгуулалтын ажлыг улам тодорхой болгосон билээ. Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-т Цагаан суврагын зэс, молибдений орд болон түүний ойр орших бусад ордуудыг түшиглэж уул уурхайн баяжуулах үйлдвэр барих, Чойрт эрчим хүчний цогцолбор, Сайншандад газрын тос боловсруулах үйлдвэр, цементийн үйлдвэр, Хавиргын улааны орд, Билүүтийн шохойн чулууны орд, Түшлэгийн базальт чулууны ордуудыг түшиглэж барилгын материалын үйлдвэр барихаар тусгасан. Дээрхи бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгаас шалтгаалах арга хэмжээ авч ажиллах болно.	30
64	2.1.27.3. Шудрага өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2010 ШӨХГ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
65	2.1.27.4 Зах зээлийн өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр	2009-2012 ШӨХГ	Хувиараа болон хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдэд төсөл боловсруулах, хууль эрх зүйн зөвөлгөө өгөх сургалт зохион байгуулж, 2009 онд 129	50



	сургалт, сурталчилгаа, үндэсний болон олон улсын хурал, семинар зохион байгуулна		иргэнийг хамруулсан ба түүнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2,6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. 2010 онд Дорноговь, Говьсүмбэр аймгийн МСҮТөвүүд болон Улаанбаатар хотын “Арука” “Ирээдүй” сургалтын төвүүд, “Хутагтын хур” төрийн бус байгууллагын Бизнесийн хөгжлийг дэмжих төвтэй хамтарч хөдөлмөрийн биржид бүртгэлтэй 339 иргэнийг суралцуулж чадамжийн гэрчилгээ олголоо. Сургалтын зардалд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 19.9 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэсэн байна. 2010 оны 5 дугаар сард Жижиг дунд үйлдвэрийн газрын дэргэдэх Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран “Бизнес төсөл боловсруулах аргачлал”, “Бизнесийн анхан шатны мэдлэг олгох сургалт”, “Бизнес санаа”, “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт” зэрэг сэдвүүдээр Сайншанд суманд сургалт зохион байгуулсан. “Хутагтын хур” төрийн бус байгууллага биенесийн хөгжлийг дэмжих төслийн уралдаанд шалгарснаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 10,8 сая төгрөгийн санхүүжилт авч хэд хэдэн удаагийн сургалт зохион байгуулаад байна.	
66	2.1.28.4. Бүсийн болон аймгийн төвд бүсийн хэмжил зүйн үйлчилгээг нэг цэгийн зарчимд шилжүүлнэ. Хэрэглээний зүйлс, барилга, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлын сорилт, шинжилгээг орчин үеийн шаардлагын хэмжээнд хийдэг сорилын лабораторийн үндэсний тогтолцоог бий болгоно	2009-2010 СХЗГ	УБТЗ-ын Эрчим хүч ус хангамжийн 2 дугаар ангийн усны тоолуурын тохируулгын лабораторийг аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс /цаашид СХЗХ гэх/ гэрээгээр ашигладаг. Хүнсний бүтээгдэхүүний хүнд элемент, хорыг тодорхойлох нэгдсэн лаборатори байгуулах зорилгоор “Нэгдсэн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх” төслийг СХЗХ боловсруулж холбогдох газруудад хүргүүлээд байна. Мөн тус хэлтэс аймгийн Эрүүл мэндийн газартай хамтарч “Эрүүл ахуйн лабораторийг бэхжүүлэх” төсөл боловсруулж Азийн хөгжлийн сорилтын сангийн төслийн нэгжид хүргүүлсэн байна. Аймгийн СХЗХ хэмжүүр, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг график, төлөвлөгөөний дагуу сумдад жилд 2-оос доошгүй удаа явж хийж байна. СХЗХ-ийн дэргэдэх лаборатори нэг цэгийн зарчмаар ажиллаж, физик, хими, хор судлал, нян судлалын үйлчилгээ үзүүлж, иргэдэд чирэгдэлгүй үйлчилж байна. Мөн халуун, хүйтэн усны тоолуурын итгэмжлэгдсэн лабораторитой болсон.	50

## 2.2. Үйлдвэржүүлэх бодлого

67	2.2.5.1 Боловсруулах үйлдвэрийн үндсэн салбаруудыг харилцан уялдаа бүхий хоршилт, төрөлжсөн хэлбэрээр хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлтийг хангах цогцолборууд байгуулна	2009-2012 ХХААХҮЯ	Монгол улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” баглагдсан. Уг бодлогын баримт бичигт: Даланзадгад-Таван толгой-Зүүнбаян, Сайншанд-Баруун-Урт - Чойбалсан чиглэлийн төмөр зам тавих, ашигт малтмалын гаралтай түүхий эд боловсруулах “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бодлогыг тусгасан юм. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд, уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барилгын материалын, коксын, ган, зэс хайлуулах болон нүүрснээс шингэн түлш гаргах үйлдвэрүүд, дулааны цахилгаан станц бүхий аж үйлдвэрийн цогцолбор байгуулах зорилт тавьсан юм. Ингэснээр төмөр замын терминал, онгоцны буудал, 100 мянган орон сууц баригдаж, 374,0 мянган ажлын байр шинээр бий болгох тооцоо хийсэн байна. Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-т Цагаан суврагын зэс, молибдений орд болон түүний ойр орших бусад ордуудыг түшиглэж уул уурхайн баяжуулах үйлдвэр барих, Чойрт эрчим хүчний цогцолбор, Сайншандад газрын тос	30
----	--	----------------------	---	----

			боловсруулах үйлдвэр, цементийн үйлдвэр, Хавиргын улааны орд, Билүүтийн шохойн чулууны орд, Түшлэгийн базальт чулууны ордуудыг түшиглэж барилгын материалын үйлдвэр барихаар тусгасан. Дээрхи бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгаас шалтгаалах арга хэмжээ авч ажиллах болно.	
68	2.2.5.2. Газар зүйн заалттай бүтээгдэхүүн бий болгох ажлыг эрчимжүүлж, нэр төрлийг олшруулна	2009-2011 ХХААХҮЯ	Орон нутгийн онцлог, байгалийн баялагт тулгуурласан үйлдвэрлэл бий болгохын тулд хайгуул судалгааны ажлыг үр дүнтэй явуулах шаардлагатай. Аймагт хайгуул олборлолтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн нарийвчилсан судалгааг гаргасан бөгөөд тэдгээрийн байгаль орчинд сөрөг нөлөөгүй, дэвшилтэт технологид суурилсан үйлдвэрлэлийг дэмжин ажиллаж байна. Тухайлбал Өргөн сумын Сөгдөхийн шохойн чулууны ордод түшиглэсэн цементийн үйлдвэр, Мандах сумын Цагаан суваргын зэсийн үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжиж ажиллаж байна.	50
69	2.2.5.3. Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг дээшлүүлэн, шинжлэх, ухаан үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.	2009-2011 ХХААХҮЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
70	2.2.5.4 Боловсруулах үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчин, инженер техникийн ажилтан бэлтгэх тусгай хөтөлбөр баталж хэрэгжүүлнэ.	2009-2012 ХХААХҮЯ	Газрын тосны чиглэлээр 2009 онд 2 оюутныг БНХАУ-ын Бээжин хотын Технологийн их сургуульд аймгийн зардлаар суралцуулж байна. Мөн Улаанбаатар Төмөр замын Сайншанд өртөөний сургалтын баазыг түшиглэн 100 залууг төмөр замын мэргэжлээр суралцуулж төгсгөсөн. Оюу толгойд ажиллах хүчин бэлтгэх сургалтанд 80 хүнийг суралцуулахаар сонгон шалгарууллаа.	50
71	2.2.6.1. Уул уурхайн үйлдвэрийг түшиглэсэн барилгын материалын үйлдвэр орон нутагт байгуулахыг дэмжинэ	2010-2011 ЭБЭХЯ	Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-т Цагаан суврагын зэс, молибдений орд болон түүний ойр орших бусад ордуудыг түшиглэж уул уурхайн баяжуулах үйлдвэр барих, Чойрт эрчим хүчний цогцолбор, Сайншандад газрын тос боловсруулах үйлдвэр, цементийн үйлдвэр, Хавиргын улааны орд, Билүүтийн шохойн чулууны орд, Түшлэгийн базальт чулууны ордуудыг түшиглэж барилгын материалын үйлдвэр барихаар тусгасан. Одоогийн байдлаар Даланжаргалан суманд “Эрэл” ХХК цементийн үйлдвэр барих саналаа ирүүлсний учир сумын 2010 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 10 га газрыг уг үйлдвэрийн зориулалтаар олгохоор сум, аймгийн ИТХ-аас баталсан байна. Өргөн суманд “Сэнж сант” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар жилд 1 сая тн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн газрын асуудлыг шийдвэрлэсэн. 2010 онд ажилчдын түр байр, үйлдвэрийн барилгын суурийн ажил, усан хангамж, цахилгаан эрчим хүчний асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлууд хийгдэж байна.	50
72	2.2.7.4 Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг нарийвчлан тогтоож, бүс нутгаар үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 68 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, ЗТБХБЯ хамтран „Сайншандад аж үйлдвэрийн цогцолбор байгуулах,, төсөл боловсруулж, 2009 оны 7 дугаар сард Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн юм. Уг төсөлд: Даланзадгад-Сайншадын төмөр зам тавих, Сайншанд-Замын-Үүдийн төмөр замын 2 дахь урсгалыг тавих, Сайншандад газрын тос боловсруулах, коксын, битумын, зэс хайлуулах, төмрийн хүдэр хайлуулах, ган хайлуулах, цемент, гипсэн хавтан үйлдвэрлэх зэрэг үйлдвэрийг 2010 оноос эхэлж, төмөр зам 2012 оноос,	50

			аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагаа 2013 оноос эхлэхээр тусгасан байна. Аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд төмөр замын терминал, онгоцны буудал, 100 мянган орон сууц баригдаж, 374,0 мянган ажлын байр шинээр бий болгох тооцоо хийсэн байна. Энэ төслийг хэрэгжүүлэх судалгааны ажил хийгдэж эхэлсэн бөгөөд тус аймагт 2009 оны 10 дугаар сард Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун болон ЗТБХБЯ-ны төлөөлөгчид, БНХАУ,БНСУ-ын хөрөнгө оруулагчид зэрэг 200 гаруй хүн ирж ажиллалаа.	
73	2.2.7.5 Аймаг, сумдын 10, 15, 35 кв-ын шугамын трассын дагуу дундын хэрэглэгчдийг хамруулж, жижиг трансформаторын дэд станц барих бодлогыг баримталж, инженерийн хийцтэй худгийн зохих хувийг цахилгаан дамжуулах агаарын шугамын дагуу гаргана.	2009-2012 ЭБЭХЯ	Хөрөнгө санхүүгийн боломж бүрдээгүйн улмаас энэ чиглэлээр ямар нэг ажил хийгдэж эхлээгүй байна.	0
74	2.2.28.1 „Сүү,, хөтөлбөрийг хэрэгжүүлж, махны нөөцийн сан байгуулна.	2009-2012 ХХААХҮЯ	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнд 2009 онд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 145,0 сая, 2010 онд 96,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Сүүний чиглэлийн үнээний тоо 2010 онд 65-аар нэмэгдэж, жилд 143,0 мянган л сүү нэмж нийлүүлэх болсноор төв суурин газрын сүүний хэрэгцээний 20,0 хувийг аймгийн дотоодын зах зээлээс нийлүүлэх боломж бүрдэж байна. Одоогийн байдлаар, нийтдээ 168 үнээ бүхий 7 фермерийн аж ахуй байгуулагдаад байгаа юм. Аймгийн төвд махны 6 цэгт 25 лангуу ажиллаж, хоногт 800-1000 кг мах борлуулдаг. Харин мал нядалгааны төвлөрсөн цэг байхгүйгээс зориулалтын бус газарт нядалсан, ченжийн гар дамжсан махыг хэрэглэгчид худалдан авч байгааг зогсоож, сум суурин газар бүрт мал нядалгааны зориулалтын цэгтэй болох зорилт дэвшүүлээд байгаа юм.	50
75	2.2.30.1 „Чацаргана,, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	“Чацаргана амин эрдэнэ” хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Даланжаргалан сумын Далантүрүү, Эрдэнэ сумын “Арван наймын худаг”, Сайншанд сумын орчим, Мандах сумын Цагаан цав зэрэг газарт урьд өмнө байсан болон шинээр тариалсан нийт 13,8 мянган ширхэг чацаргана ургаж байгаа юм. Үүнээс 2010 онд 4,0 мянга гаруйг нь тариалсны дотор “Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент” төслөөр Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн суманд нийтдээ 320 ш, АДРА олон улсын байгууллагын төслөөр Эрдэнэ, Сайншанд, Даланжаргалан суманд нийтдээ 400 ш чацаргана тариалжээ. Айраг сумын 1 иргэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 10,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 1 га газарт чацарганын суулгац тариалаад байна.	70
<b>2.3. Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдлын бодлого</b>				
76	2.3.1.2 Сүүний хангамжийг нэмэгдүүлэн, сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулан, удаан хугацаагаар хадгалагдах сүү, сүүн	2009-2012 ХХААХҮЯ	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнд 2009 онд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 145,0 сая, 2010 онд 96,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Сүүний чиглэлийн үнээний тоо 2010 онд 65-аар нэмэгдэж, жилд 143,0 мянган л сүү нэмж нийлүүлэх болсноор төв суурин газрын сүүний	50

	бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ		хэрэгцээний 20,0 хувийг аймгийн дотоодын зах зээлээс нийлүүлэх боломж бүрдэж байна. Одоогийн байдлаар, нийтдээ 168 үнээ бүхий 7 фермерийн аж ахуй байгуулагдаад байгаа юм.	
77	2.3.1.3 Малчид, фермерүүдийн бэлтгэсэн сүүг сүү үйлвэрлэгчид нэгдсэн байдлаар цуглуулж, хөргөх, боловсруулах сүү бэлтгэлийн тогтолцоог бүрдүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	2009 онд сүүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авах болон фермерээ өргөтгөх төсөл боловсруулан шалгаруулалтанд тэнцсэн 6 иргэнд 142.0 сая төгрөгний зээлийн санхүүжилт олгон үйл ажиллагааг нь дэмжин ажиллаж байна 2008 онд нийт сүүний хэрэгцээний 4.8 хувийг хангаж байсан бол 2009 онд 20,0 хувь болж өсөх хандлагатай байна.	50
78	2.3.1.4. Буудайн гурилыг амин дэм, эрдэс бодисоор баяжуулахад шаардагдах холигч төхөөрөмж, премиксийг хөнгөлөлттэй нөхцлөөр нийлүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
79	2.3.1.5 “Ногоон хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг 2009, 2010 онуудад Сайншанд суманд зохион байгуулсан, “Шинэ Дорноговь”, хөгжлийн сангаас хөрөнгө гаргаж, Оросын сайн чанарын Романо сортын урийн төмс татан авч тариалан эрхлэгчдэд олгосон, улсын төсвийн 12,0 сая төгрөгийн хөрөнгөөр Иххэт суманд услалтын систем суурилуулсан. Газар тариалан эрхлэх анхны мэдэгдэхүүн олгох сургалтыг Мандах, Улаанбадрах, Алтанширээ, Хатанбулаг, Иххэт сумдад зохион байгуулж 128 ногоочид хамрагдсан байна. “Дорноговь түншлэл-2010” аймгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан. Сумдад хүлэмж, зоорь барих ажилд нийтдээ 97.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. 12 суманд нийт дүнгээрээ 430 тн-ын багтаамжтай зоорь барьсан бөгөөд тэдгээрийг гэрээгээр эзэмшүүлж, ашиглалтыг сайжрууллаа. Мөн нийт дүнгээрээ 2040 кв.м талбай бүхий 9 хүлэмжийн аж ахуй ажиллаж байсан, 2010 онд БНСУ-ын буцалтгүй тусламжаар 300 кв.м талбай бүхий 2 хүлэмж Мандах суманд нэмж байгуулагдсанаар 11 хүлэмжтэй болоод байна. 2009 онд 183.7 тн төмс, 144.7 тн хүнсний ногоо хураан авч байсан бол 2010 онд 208,3 тн төмс, 277,5 тн хүнсний ногоо хураан авсан байна. 2010 онд хураан авсан төмс өмнөх оныхоос 11,3 хувь, хүнсний ногоо 91,4 хувиар тус тус нэмэгдэж, төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 22,0 хувийг аймгийн дотоодын ургацаас хангах боломж бүрдлээ.	70
80	2.3.1.6 Дотоодын хүнсний түүхий эдэд тулгуурласан нярай хүүхдийн хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ	2009-2012 ХХААХҮЯ	Сайншанд сумын хүүхдийн 2-р цэцэрлэгийн дэргэдэх Эх хүүхдийн хоол тэжээлийн төв иргэд, аж ахуйн нэгжээс нийлүүлсэн сүүг боловсруулж, 7 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 4тн тараг бэлтгэж, бага насны хүүхэд, өндөр настанд үйлчилсэн байна. Тус төв сувилалын зориулалтаар тэжээллэг хоол, ундааны зүйл бэлтгэж хэрэглэгчдэд нийлүүлдэг.	50
81	2.3.5.1. Тариалангийн талбайн бүртгэл, тооллого явуулж, эзэмшилт, ашиглалтыг сайжруулна	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
82	2.3.5.2. Таримал ургамал, үр үржүүлгийн аж ахуй байгуулах, үрийн сорт, нэр төрлийг олшруулах, ганд тэсвэртэй болон	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-

	усалгаатай нөхцөлд тариалах сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна			
83	2.3.5.3. Улаан буудайн нөөц бүрдүүлэх, хүрэлцээ, хангамжийг сайжруулах зорилгоор борлуулалтын сүлжээ бий болгоно	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
84	2.3.5.4 “Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Улсын төсвийн 12,0 сая төгрөгийн хөрөнгөөр Иххэт суманд услалтын систем суурилуулсан. “Дорноговь түншлэл-2009”, “Дорноговь түншлэл-2010” аймгийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, Улаанбаатар хот болон бүсийн чанартай үзэсгэлэн, уралдаануудад манай аймгийн тариаланчид амжилттай оролцож ирлээ. Сумдад хүлэмж, зоорь барих ажилд нийтдээ 97.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. 12 суманд нийт дүнгээрээ 430 тн-ын багтаамжтай зоорь барьсан бөгөөд тэдгээрийг гэрээгээр эзэмшүүлж, ашиглалтыг сайжрууллаа. Мөн нийт дүнгээрээ 2040 кв.м талбай бүхий 9 хүлэмжийн аж ахуй ажиллаж байсан, 2010 онд БНСУ-ын буцалтгүй тусламжаар 300 кв.м талбай бүхий 2 хүлэмж Мандах суманд нэмж байгуулагдсанаар 11 хүлэмжтэй болоод байна. 2009 онд 183.7 тн төмс, 144.7 тн хүнсний ногоо хураан авч байсан бол 2010 онд 208,3 тн төмс, 277,5 тн хүнсний ногоо хураан авсан байна. 2010 онд хураан авсан төмс өмнөх оныхоос 11,3 хувь, хүнсний ногоо 91,4 хувиар тус тус нэмэгдэж, төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 22,0 хувийг аймгийн дотоодын ургацаас хангах боломж бүрдлээ.	50
85	2.3.6.1. Нутгийн, сайжирсан, цэвэр үүлдрийн малын удмын санг хамгаалах, өсгөх, мал үржүүлгийн болон биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Аймгийн шилмэл малын үзэсгэлэн худалдааг 2009, 2010 онуудад Сайншанд суманд зохион байгуулсан, мөн Айраг, Иххэт, Сайхандулаан, Өргөн сумд сумынхаа хэмжээнд зохион байгуулж, шилмэл малыг шалгаруулж шагнаж олгож байв. Улаанбаатар хотод зохион байгуулсан “Шилмэл мал” үзэсгэлэн худалдаанд тус аймаг амжилттай оролцож 1 мөнгөн медаль авсан. 2009 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 295,4 мянган толгой цэвэр, эрлийз омгийн мал байгаа нь нийт мал сүргийн 31,7 хувь болж байв. 2010 оны жилийн эцсийн байдлаар дээрхи төрлийн мал сүргийн тоо 359,9 мянга болж өмнөх оныхоос 22.0 хувиар өссөн байна. Монгол улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөр баталж, 223 дугаар тогтоолоор сумдын ЗДТГ-т мал эмнэлэг, үржлийн албаны нэгж байгуулсан нь малын үүлдэр угсааг сайжруулах, гойд ашиг шимт болон торгон сүргийн малыг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх бүтцийг бий болгосон билээ.	50
86	2.3.6.2 Тэмээний удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, өсгөх, ашиг шимийг зохистой ашиглах замаар тэмээчдэд дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	“Тэмээн сүргийн тогтвортой өсөлтийг хангах бодлого”-ыг аймгийн Засаг даргын 2009 оны 392 дугаар захирамжаар баталсан. Тэмээний аж ахуйг хөгжүүлэх талаар зохиосон ажлын үр дүнд 2009 оны эцэст 26,1 мянган тэмээ тоолуулж, өмнөх оныхоос 4,0 хувиар өсгөсөн. Тэмээг хамгаалах гол арга хэмжээ болгож бойжуулсан ботго тутамд 5,0 мянган төгрөгөөр тооцож малчинд урамшил олгож байхаар аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэсэн. Мөн тэмээний аж ахуйтай холбогдох ажил мэргэжлийн уралдаан, тэмээн поло наадам, хурдан тэмээний уралдааныг аймгийн хэмжээнд болон тэмээ олонтой сумдад зохион байгуулж байгаа. 2010 онд Үндэсний	70

			спортын IV наадмын тэмээн поло, хурдан тэмээний уралдааныг аймагтаа амжилттай зохион байгуулж, улсад шагналт 6 дугаар байранд орсон.	
87	2.3.6.3 Цөм сүргийн малыг үржлийн бүртгэлд бүрэн хамруулж, арвин ашиг шимт цөм сүргийн малын удмын гарваль, ашиг шимийн мэдээллийн сан бий болгоно	2009-2012 ХХААХҮЯ	Аймгийн хэмжээнд 359,9 мянган толгой цэвэр, эрлийз омгийн мал байгаа нь нийт мал сүргийн 35,2 хувийг эзэлж байна. Арвин ашиг шимт цөм сүргийн малын удмын гарваль, ашиг шимийн мэдээллийн санг аймгийн ХХААЖДҮГ дээр бий болгож баяжуулж ашиглаж байна.	50
88	2.3.6.4 Малын үржлийн ажил, үйлчилгээний хүртээмж, үр дүнг сайжруулах зорилгоор цөм сүргийн үржлийн нэгжийн чадавхийг сайжруулах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авна	2009-2012 ХХААХҮЯ	Монгол улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөр баталж, 223 дугаар тогтоолоор сумдын ЗДТГ-г мал эмнэлэг, үржлийн албаны нэгж байгуулсан нь малын үүлдэр угсааг сайжруулах, гойд ашиг шимт болон торгон сүргийн малыг хамгаалах төрийн бодлогыг хэрэгжүүлэх бүтцийг бий болгосон билээ. Орон нутагт энэ шийдвэрийг хэрэгжүүлж, шаардагдах төсвийг 2011 оны төсвийн төсөлд тусгаад байна.	70
89	2.3.7.1. Эрчимжсэн мал ахуй эрхлэх бүс нутгуудыг аймаг, сум бүрээр тогтоож, тухайн бүс нутагт буй бэлчээрийн малыг өндөр ашиг шимт малаар сольж, өөрчлөх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2009 онд 156.7 сая, 2010 онд 240.7 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Зээлийн хөрөнгийн 70 гаруй хувь нь сүүний фермерийн аж ахуй байгуулах, өргөтгөхөд чиглэгдэж, одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 168 үнээ бүхий фермерийн хэлбэрийн 7 аж ахуй үүсэн байгуулагдаад байна. Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооны салбар зөвлөл тус аймагт 23 гишүүнтэйгээр байгуулагдлаа.	70
90	2.3.7.2 Сүү, махны арвин ашиг шимт мал, амьтны тоог нэмэгдүүлэх, үржлийн сүрэг бий болгох үйл ажиллагааг урамшуулна	2009-2012 ХХААХҮЯ	ХХААЖДҮГазар Төв аймгийн Баянчандмань сумаас махны чиглэлийн торгууд монголын эрлийз хуц 1, Завхан буурал сүүний чиглэлийн ухна 4-ийг орон нутгийн төсвийн 781.9 мянган төгрөгийн хөрөнгөөр худалдан авч, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх санаачлага гаргасан иргэдэд олгосон. Өндөр ашиг шимтэй малын үзэсгэлэн, дуудлага худалдааг жил бүр зохион байгуулж ирсэн.	70
91	2.3.7.3 Бүсийн тулгуур төв болон орон нутгийн хөгжлийн төвүүдийн ойролцоо фермерийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх загвар бий болгоход дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдэд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 2009 онд 156.7 сая, 2010 онд 240.7 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгосон. Зээлийн хөрөнгийн 70 гаруй хувь нь сүүний фермерийн аж ахуй байгуулах, өргөтгөхөд чиглэгдэж, одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 168 үнээ бүхий фермерийн хэлбэрийн 7 аж ахуй үүсэн байгуулагдаад байна.	50
92	2.3.8.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бирж байгуулж ажиллуулна	2009-2012 ХХААХҮЯ	Хөдөө аж ахуй, үүний дотор мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрлэл, бараа, түүхий эдийн бирж байгуулах ажлыг удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2010 оны а/173 дугаар захирамжаар байгуулж ажиллуулж байна. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн борлуулах зах байгуулах газрын дуудлага худалдааг Сайншанд суманд 2010 онд зохион байгуулсан. ДЕВКО ХХК уг газрыг 96,5 сая төгрөгөөр худалдан авч, зах байгуулах ажилдаа ороод байна. Сумдад сүү, цагаан идээ болон төмс, хүнсний ногоо худалдах төвлөрсөн цэг байгуулах, мал нядалгааны газар байгуулах, арьс шир, ноос ноолуурын биржийн худалдаа эрхлэх санал бүхий 12 иргэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас нийтдээ 141,4 сая төгрөгийн зээл авч, үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна.	50

93	2.3.8.2. Сум бүрт түүхий эд бэлтгэлийн анхан шатны хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Мандах, Даланжаргалан сумдын ХАА-н хоршоо, Эрдэнэ сумын „Бүрдэнэ,, Сайншанд сумын „Загийн говь,, „Дэлгэр говь,, зэрэг хоршоод тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.	50
94	2.3.10.1 “Малын тэжээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Байгаль, цаг агаарын тааламжгүй нөлөөлөл, усны хүрэлцээнээс шалтгаалж малын тэжээлийн ургамал тариалах нь тус аймагт хүндрэлтэй. Малчдын бүлэг байгуулагдаж төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр бага хэмжээний газрыг хашиж байгалийн жамаар ургац байгаа ургамалыг хамгаалах төдий хэмжээнд үйл ажиллагаа явагдаж байна. Тухайлбал, “Цөлжилтийг бууруулах, газрын тогтвортой менежмент” төслийн хүрээнд Дэлгэрэх, Өргөн, Алтанширээ, Иххэт, Эрдэнэ, Хөвсгөл сумдад малчдын бүлэг, хоршоо байгуулагдаж, бэлчээрийг хашиж малын тэжээлийн ургамал болон хүнсний ногоо тариалах, хадлан тэжээл хамтран бэлтгэх, бэлчээр усжуулах, худаг, уст цэгийг хамгаалах ажлыг хийж байгаа юм. Сайншанд болон зарим суманд ажиллаж байгаа фермерийн хэлбэрийн аж ахуй бага хэмжээний газарт малын тэжээлийн ургамал тариалж эхэлсэн.	50
95	2.3.10.2. Хадлан болон тэжээл үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлж, тэжээлийн хангамж, чанарыг сайжруулах, хадгалалт, тэвэрлэлтийн зардлыг бууруулах арга хэмжээ авна	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
96	2.3.11.3 Аймаг, сумдын отрын бэлчээр нутгийг өргөжүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ. Отрын бүс нутгийн бэлчээрийн нөхөн сэргээлт, хамгаалалтыг сайжруулан зохистой ашиглах арга хэмжээ авна	2009-2012 ХХААХҮЯ	Тус аймагт отрын бэлчээр нутаг гэж хуваарилсан газар байхгүй. Өөрийн аймгийн болон гаднын аймаг, сумын малчид аль боломжтой газар нутагт оторлож, нутгийн захиргааны байгууллагатай гэрээ, хэлэлцээр хийх замаар зохицож амьдарч байгаа юм.	50
97	2.3.12.2 Хил дамжин халдварладаг малын гоц халдварт шүлхий, хонь ямааны цэцэг, гахайн мялзан, шувууны томуу өвчний дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэн, тайван нөхцлийг хангаж ажиллана.	2009-2012 ХХААХҮЯ	“Малын сэг, зэмийг устгах, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 246 дугаар тогтоол, Улсын Онцгой Комиссын 2010 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 14 дүгээр хуралдааны шийдвэр, “Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2010 оны 246 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Аймгийн Засаг даргын 2010 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн а/398 тоот захирамжаар мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар 5,6 сая төгрөгийн хөрөнгийг малчдад туслах хандивын сангаас шийдвэрлэсэн байна. 2010 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 635,5 мянга, туулгалтанд 2,0 мянга, гуурын боловсруулалтанд 10,0 мянга, угаалганд 22,3 мянган малыг хамруулсан. Шүлхий өвчин гарсан аймгуудтай хил залгаа оршиж байгаа сумдад хяналтын цэг, хөдөлгөөнт эргүүл ажиллуулахтай холбогдуулан 5.6 сая төгрөгийн хөрөнгийг “Малчдад туслах хандив”-ын сангаас шийдвэрлэж, урьдчилан сэргийлэх тарилгыг 413,2 мянган малд хийлээ.	50

98	2.3.12.6 “Мал эмнэлэг, үржлийн анхан шатны үйлчилгээний нэгжийг дэмжих хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж, сумын мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжүүдийг бэхжүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	“Сумдад мал эмнэлэг, үржлийн албаны нэгж байгуулах тухай” Монгол улсын Засгийн газрын 2010 оны 223 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, сумдын ЗДТГ-ын бүтцэд мал эмнэлэг, үржлийн албаны нэгжийг байгуулсан.	90
99	2.3.13.3 4000 худаг шинээр гаргаж, 1000 худаг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	2010 онд улсын төсвийн 148,5 сая төгрөгийн хөрөнгөөр 7 худаг гаргаж, 30 худагт их засвар хийлээ. Мөн Япон улсын “Өвсний үндэс” төслийн хөрөнгөөр 3 худаг шинээр гаргаж, 6 худагт их засвар хийлээ. Энэ ажлыг Улаанбаатар хотын “Цахиурт баян” ХХК гүйцэтгэсэн байна. Улсын төсвийн 160,0 сая төгрөгийн хөрөнгөөр усны хайгуулын ажлыг 5 сумын 80 цэгт Улаанбаатар хотын “Нэмэр интернэшл” ХХК гүйцэтгэсэн. “Тогтвортой амьжиргаа-2” төслөөр энгийн уурхайн 64 худгийг шинээр гаргасан буюу засварласан. Дээрхи арга хэмжээнүүдийн үр дүнд бэлчээрийн нийт талбайн 41,9 хувь нь усжуулагдаж, усжуулсан талбайн хэмжээ өмнөх оныхоос 1,9 хувиар нэмэгдсэн байна.	50
100	2.3.13.4 Газрын дорхи усны геофизикийн хайгуул хийж, 1600 уст цэгийг шинээр тогтооход дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	2009-2010 онд Мандах, Хатанбулаг, Хөвсгөл, Улаанбадрах сумдын нутагт нийт 71 цэгт газрын дорхи усны геофизикийн хайгуул хийлгэх саналыг ХХААХҮЯ–нд хүргүүлээд байна. Улсын төсвийн 160,0 сая төгрөгийн хөрөнгөөр усны хайгуулын ажлыг 5 сумын 80 цэгт Улаанбаатар хотын “Нэмэр интернэшл” ХХК 2010 онд гүйцэтгэсэн	70
101	2.3.13.5. Жил бүр 100.0 мянган га-д царцаатай, 500.0 мянган га-д мэрэгчтэй тэмцэх ажлыг гүйцэтгэж, ашиглах бэлчээрийг нэмэгдүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
102	2.3.13.6. Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна	2009-2011 ХХААХҮЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
103	2.3.14.1 “Хоршоог дэмжих хөтөлбөр” хэрэгжүүлж, мал борлуулах, түүхий эд бэлтгэх чиглэлээр сум, дүүрэг, тосгонд иргэдийн хоршоо, нөхөрлөл байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 96 дугаар тогтоолоор „2009-2017 онд хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр,-ийг баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх чиглэлийн хоршоо байгуулах, өргөтгөх санаачлагыг илүү анхаарч дэмжихээр тусгасан.	50
104	2.3.16.1 “Мал сүргийг зарим халдварт өвчнөөс сэргийлэх хөтөлбөр”-ийг боловсруулан хэрэгжүүлж, өрх, баг, сум, аймгийн түвшинд эрүүлжилтийг баталгаажуулан гэрчилгээжүүлэх арга хэмжээ авна	2009-2012 ХХААХҮЯ	Мал сүргийг халдварт өвчнөөс сэргийлэх ажил зохих ёсоор хийгдэж байна. Бруцеллёзын цагирган урвалын шинжилгээг 600 дээжид, адууны ям өвчний харшил сорилын шинжилгээг 4000 адуунд, сүрьеэ өвчний харшил сорилын шинжилгээг 3000 үхэрт тус тус хийлээ. Цаашид хүн амыг аюулгүй хүнсээр хангах зорилгоор малын сүү болон мах махан бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээг тогтмол хийх нөхцлийг бүрдүүлж, бүтээгдэхүүнийг гэрчилгээжүүлэх ажлыг хийж байна.	50
105	2.3.17.1. Байгаль экологид сөрөг нөлөөгүй техник, технологи нэвтрүүлэх замаар өнжөөсөн болон атаршсан талбайг эргэлтэнд оруулна	2009-2012 ХХААХҮЯ	Тус аймаг газар тариалангийн бүс нутагт хамаардаггүй, орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-



106	2.3.17.2. Тэг болон цомхотгосон аргаар бэлтгэх уриншийн хэмжээг 50.0 мянган га талбайд хүргэнэ	2009-2012 ХХААХҮЯ	Тус аймаг газар тариалангийн бүс нутагт хамаардаггүй, орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
107	2.3.18.1 Зоорь, агуулахын төрөлжсөн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэн, тохоохон суурин газруудад хүнсний ногооны төрөлжсөн бөөний худалдааны зах, биржийн тогтолцоо бүрдүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан “Агропарк” төслийг орон нутагтаа хэрэгжүүлж, 13 суманд, нийт дүнгээрээ 430,0 тн-ын багтаамжтай зоорь барьсан, тэдгээрийг эзэмшиж ашиглах иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллаж байна.	50
<b>2.4. Дэд бүтэц, хот байгуулалтын бодлого</b>				
108	2.4.5.2 Монгол улсын иргэнд үнэгүй өмчлүүлэх боломжтой газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	2009-2012 ЗТБХБЯ	Аймгийн газар зохион байгуулалтын 2009 оны ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2008 оны 2/07 дугаар тогтоолоор, 2010 оны ерөнхий төлөвлөгөөг 2009 оны 4/08 тогтоолоор тус тус баталж, төлөвлөгөөний дагуу газар олголтыг ил тод зохион байгуулж ирсэн. Уг төлөвлөгөөнд зайлшгүй шаардлагаар, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 10 удаагийн тогтоолоор өөрчлөлт оруулсан. 2010 оны төлөвлөгөөнд хот тосгон, бусад суурины 3061,7 га, хөдөө аж ахуйн 163,3 га, нийт 3225,1 га газрыг өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулахаар тусгасан, 2010 оны 11 дүгээр сарын байдлаар хот тосгон, бусад суурины 2869,2 га, хөдөө аж ахуйн 119,5 га, нийт 2988,7 га газрыг 305 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан байна. Одоогийн байдлаар төлөвлөгөөний гүйцэтгэл 92,6 хувьтай байна.	50
109	2.4.5.3 Нийслэлийг аймгийн төвүүдтэй холбосон улсын чанартай авто замын дагуу иргэдэд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоож, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна	2009-2012 ЗТБХБЯ	Чойр-Сайншанд-Замын-үүдийн чиглэлийн авто замыг барьж, бүрэн ашиглалтад оруулах хүртэл уг замын дагуу газар олгох асуудлыг шийдвэрлээгүй байгаа	0
110	2.4.5.4 Аж ахуйн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлэх газар тариалангийн болон эрчимжсэн фермерийн аж ахуйн зориулалтын газрын хэмжээ, байршлыг тогтоон, өмчлүүлэх ажлыг зохион байгуулна.	2009-2012 ЗТБХБЯ	2010 оны 11 дүгээр сарын байдлаар хот тосгон, бусад суурины 2869,2 га, хөдөө аж ахуйн 119,5 га, нийт 2988,7 га газрыг 305 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулсан байна.	50
111	2.4.6.5 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг эргэлтийн цэгийн солбицлоор тодорхойлон баталгаажуулах ажлыг хийж, солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлнэ	2009-2012 ЗТБХБЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана, орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
112	2.4.7.1 Шинэ хотхон, хороолол барих ажлын хүрээнд 37,0 мянган орон сууц барина	2009-2012 ЗТБХБЯ	Сайншанд суманд хувийн /оршин суугчдын/ хөрөнгө оруулалтаар 60, 30, 30, 65 айлын сууцны барилга баригдаж, нэг 30 айлын орон сууц нь 2009 оны 11 дүгээр сард ашиглалтанд орсон. 2 дугаар багийн нутаг дэвсгэрт орон сууцны санхүүжилтийн корпорацийн хөрөнгөөр 20 айлын орон сууц 2009 оны 07 дугаар сард ашиглалтанд орсон.	70

			Оршин суугчдын хөрөнгөөр, Сайншанд суманд “Тулга констракшн” ХХК-ын барьсан 60 айлын сууц 2010 оны 9 дүгээр сард ашиглалтанд орсон. Мөн компанийн барьж байгаа 65 айлын сууц ондоо багтаж ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байгаа. Харин “ТОБЭМ” ХХК-ын барьж байгаа 30 айлын сууцны 3 давхрын рамын цутгалт хийгдээд, өрлөгийн ажил нь зогсонги байдалд орсон. “Говь баян нуур” ХХК АУК-ын ард 48 айлын сууцны барилгыг 2010 онд эхэлсэн, ажил үргэлжлэн явагдаж байна Замын- Үүд суманд 32 айлын орон сууц 2009 оны 10 дугаар сард хэсэгчлэн ашиглалтанд орсон, 32, 38, 48 айлын орон сууцны барилгууд баригдаж байгаа. Мөн тус суманд Цагдаагийн ажилчдын 96 айлын, багш нарын 30 айлын, төмөр замчдын 66 айлын, шүүхийн 48 айлын, мэргэжлийн хяналтын ажилтнуудын 35 айлын орон сууцны барилгууд баригдаж байна. Айраг суманд “Тулга констракшн” ХХК төрийн албан хаагчийн 30 айлын сууц барьж байна.	
113	2.4.11.1 Говийн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулна	2009-2012 ЗТБХБЯ	Монгол улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” батлагдсан. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай УИХ-ын 2010 оны 36 дугаар тогтоол гарсан. Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Өмнөд говийн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр” батлагдсан. Бүс нутгийн хөгжлийн талаар баримтлах төрийн бодлого ийнхүү тодорхой болсон тул “Дорноговь аймгийн 2010-2021 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-ын 2010 оны 6 дугаар хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	50
114	2.4.11.2 Таван толгой, Оюу толгой, Цагаансуврагын орд газрыг түшиглэсэн бүс нутгийн стратеги, хот байгуулалтын төлөвлөгөө боловсруулна	2009-2012 ЗТБХБЯ	Монгол улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого” батлагдсан. Уг бодлогын баримт бичигт: Даланзадгад-Таван толгой-Зүүнбаян, Сайншанд-Баруун-Урт - Чойбалсан чиглэлийн төмөр зам тавих, ашигт малтмалын гаралтай түүхий эд боловсруулах “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолбор байгуулах бодлогыг тусгасан юм. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хүрээнд, уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, барилгын материалын, коксын, ган, зэс хайлуулах болон нүүрснээс шингэн түлш гаргах үйлдвэрүүд, дулааны цахилгаан станц бүхий аж үйлдвэрийн цогцолбор байгуулах зорилт тавьсан юм. Ингэснээр төмөр замын терминал, онгоцны буудал, 100 мянган орон сууц баригдаж, 374,0 мянган ажлын байр шинээр бий болгох тооцоо гараад байгаа юм.	30
115	2.4.23.1 Орчин үеийн тээвэр ложистикийн төв, терминал аж ахуйг Замын-Үүд боомтод байгуулна	2009-2012 ЗТБХБЯ	Замын-Үүд сумын төвд барих улс, хот хоорондын авто вокзалын барилгын зураг төслийг боловсруулсан, 2,6 га газар олгосон, одоогийн байдлаар орчны хашаагаа бариад байна. “Концессын зүйлийн жагсаалт батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2010 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 198 дугаар тогтоолоор Замын-Үүд суманд хот хоорондын зорчигч, ачаа тээврийн авто вокзал барих асуудлыг концессын зарчмаар шийдвэрлэхээр тогтоосон байна.	30
116	2.4.36.1 Замын-Үүдийн хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулж, улсын зэрэглэлтэй хотын статустай болгох асуудлыг боловсруулж УИХ-аар батлуулна	2009-2012 ЗТБХБЯ	Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 90 дүгээр захирамжаар Замын-Үүд сумын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ахлагчаар нь Монгол улсын сайд, Засгийн газрын ХЭГ-ын даргыг томилон ажиллуулж байгаа. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ЗТБХБЯ-ны захиалгаар „Проект Х,, компани 2007-2009 онд боловсруулсан, үүнийг Замын-Үүдийн чөлөөт бүсийн	

			ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж шинэчлэн боловсруулах шаардлага тавигдсан юм. Улсын төсвийн 332,0 сая төгрөгийн хөрөнгөөр тус сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Монголын хот байгуулалтын хүрээлэн, Ти энд Жи ХХК, АЕКОН ХХК, Эрчим төсөл, Ордгео ХХК, Орхон геотех ХХК зэрэг байгууллагууд консерциум хэлбэрээр хамтран боловсруулж байгаа ба 2010 оны 11 дүгээр сарын эхээр орон нутаг дахь хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-г хийсэн. Уг төлөвлөгөөг мөн сард багтаан хүлээлгэж өгөх зорилготой ажиллаж байгаа юм. Мөн тус сумын дулааны станцын техник, эдийн засгийн үндэслэлийг „Мон энерги консалтинг,, ХХК, цэвэр усны шугам, цэвэрлэх байгууламжийн зураг төслийг „Престиж инженеринг,, ХХК тус тус гүйцэтгэж байгаа болно.	100
<b>2.5. Орон нутгийн хөгжлийн бодлого</b>				
117	2.5.2.2 Баг бүрийг өрхийн амьжиргааг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн 1,0 саяас доошгүй төгрөгийн эх үүсвэртэй, эргэн төлөгдөх нөхцөл бүхий хөгжлийн сантай болгоно	2009-2012 ХХААХҮЯ	Эхний ээлжинд сум бүрийг сум хөгжлийн сантай болгох бодлого баримталж, зарим арга хэмжээ авсан. Аймгийн ИТХ-ын 2009 оны 06 дугаар тогтоолоор „Шинэ Дорноговь хөгжлийн сан,,-г байгуулсан бөгөөд энэ сангаас сумдын хөгжлийн санд нийтдээ 39,1 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэж дэмжлэг үзүүлсэн. Мөн энэ сангаас Иххэт сумын нэгдүгээр багийн төвийг шинээр байгуулахад зориулж 5,5 сая төгрөгийн хөрөнгө олгосон. Багийн иргэд санаачлагаараа багийн хөгжлийн сантай болох эхлэл зарим суманд тавигдсан. Энэ сангаас малгүй буюу цөөн малтай өрхийг малжуулах, багт зохиогдох хурал зөвлөгөөн, урлаг, соёл, биеийн тамир спортын арга хэмжээний зардлыг хариуцах, багийн төвийг тохижуулах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, өргөтгөх саналтай иргэдэд хүү багатай зээл олгох зэрэг ажлыг санхүүжүүлж байна.	90
118	2.5.3.6 Аймгийн төвүүдийн дулаан хангамжийн байдалд судалгаа хийж, шинэчлэлтийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна	2009 ЭБЭХЯ	Сайншанд сумын дулааны станцын 1, 2, 3 дугаар зуухнуудын экран хоолой, коннектив, вентилятор, дымососыг солих, 1, 3 дугаар зууханд химийн угаалга хийх, 3 дугаар зууханд яндан угсралт хийх, тэжээлийн усны шүүлтүүр тавих зэрэг ажлыг одоогоор хийж, 185,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулаад байна. Улсын төсвийн 591,3 сая төгрөгийн хөрөнгөөр Зээгийн хөтлөөс цэвэр ус дамжуулах шугамын 6,9 км хэсгийг РЕ хоолойгоор сольсон.	50
119	2.5.3.7 Аймгийн төвийн дулааны станц, дулаан хангамжийн системийн харъяалал, өмчийн хэлбэр, шугам сүлжээний хил заагийг тогтоож, дулаан хангамжийн зуух, тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх, халаалтын доголдлыг бүрэн арилгаж, хэрэглээний халуун усны системтэй болгоно	2009-2012 ЗТБХБЯ	Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих “Говийн зүүн өмнөд бүсийн хот суурин газар, хилийн хотуудыг хөгжүүлэх төсөл”-д тус аймаг хамрагдах болж, төслийн гэрээнд аймгийн Засаг дарга 2010 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан. Уг төслийн хөрөнгөөр Сайншанд сумын төвлөрсөн халаалтын 4 зуух, цэвэр усны 16.3 км, бохирын 23.1 км, дулааны 11.5 км шугам, цэвэрлэх байгууламжийг шинэчлэх бөгөөд холбогдох тооцоо судалгааг ЗТБХБЯ, ҮХШХ, Сангийн яаманд хүргүүлээд байна. Сайншанд сумын нийтийн орон сууцыг хэрэглээний халуун устай болгох асуудлыг аймгийн “Чандмань-Илч” ОНӨ ХХК хариуцаж, Сайншанд сумын Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаж байгаа, эхний ээлжинд 1 дүгээр 58 айлын орон сууцны айл өрхүүдийг халуун усны тоолууртай болгож, усны нэгдсэн халаагуур /бойлер/ тавьсан, цаашид бусад орон сууцнуудыг хэрэглээний халуун устай болгох зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай байгаа.	30

120	2.5.4.1 Улсын төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сан, дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, засвар, шинэчлэлт хийнэ	2009-2012 ЭБЭХЯ	Шивээ овоо-Халзан уулын 6 квт-ын, 30 км, цахилгаан дамжуулах агаарын шугамыг улсын төсвийн 249,0 сая төгрөгийн хөрөнгөөр Улаанбаатар хотын “MISS” ХХК барьж ашиглалтанд хүлээлгэн өгөхөд бэлэн болгоод байна. Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв хүчдэл залгах ажлыг гүйцэтгэж байна. Дэлхийн банкны буцалтгүй тусламж болон бусад төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр Мандах, Хатанбулаг, Даланжаргалан, Замын-Үүд, Дэлгэрэх, Иххэт сумын төвийн 04 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын засвар, шинэчлэлт хийлээ.	50
121	2.5.6.3 Орон нутгийн эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан бетон, төмөр бетон, дуу чимээ, дулаан тусгаарлах ханын материалын үйлдвэрийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ	2009-2012 ЗТБХБЯ	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зээлийн хөрөнгөөр блокны үйлдвэр 5, тоосгоны үйлдвэр 1 шинээр байгуулагдаж орон нутгийн түүхий эдэд түшиглэсэн барилгын материалын үйлдвэрлэлийг эхлүүлээд байна. Мөн Тээлийн шонхор ХХК-ийн цементийн үйлдвэр Сайншанд суманд ажиллаж байна, мөн “Сэнж сант” ХХК-ийн цементийн үйлдвэр, МАК-ийн цемент, шохойн үйлдвэрийн барилгын ажил эхлээд байна.	30
122	2.5.7.2. Алслагдсан болон говийн бүсийн хүнд нөхцөлд ажиллаж амьдарч байгаа иргэдэд нийгмийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг судалж шийдвэрлэнэ	2011-2012 НХХЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
123	2.5.9.1 Сургуулийн дотуур байр, эмнэлэг, соёлын төвийг шинээр барих, өргөтгөх, засварлах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ	2009-2012 БСШУЯ, ЭМЯ	Өргөн сумын дотуур байрны шинэ барилгыг 2009 онд ашиглалтанд хүлээж авсан, түүнд орон нутгийн төсвөөс хөрөнгө шийдвэрлэж 50 ор авч нийлүүлсэн. “Боловсролын хөгжлийн хөтөлбөр”-ийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр Хатанбулаг сумын сургуулийн дотуур байрны их засвар, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачлагын түншлэл” төслийн 230,0 сая төгрөгийн хөрөнгөөр Эрдэнэ сумын сургуулийн дотуур байрны их засварыг хийж, “Тогтвортой амьжиргаа-II” төслийн хөрөнгөөр Даланжаргалан, Сайхандулаан, Дэлгэрэх, Замын-Үүд, Иххэт, Хөвсгөл, Улаанбадрах сумын дотуур байрны гал тогоонд тоног төхөөрөмж, дотуур байрны ор, эд хогшил нийлүүлж, тохижилтын ажлыг гүйцэтгэсэн байна. Нэгдсэн эмнэлгийн сантехник, лифтний засварыг 2009 онд улсын төсвийн 200,0 сая төгрөгийн хөрөнгөөр Улаанбаатар хотын „Магма од,, ХХК гүйцэтгэсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, Өргөн сумын эмнэлэг, Сайншанд сумын “Агадова” өрхийн эмнэлэгт нийтдээ 159.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй засвар, шинэчлэлтийн ажил хийгдсэн. “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр Улаанбадрах, Хатанбулаг сумдын эмнэлэгт засвар, тохижилтын ажил, хийсэн, Сайншанд, Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Өргөн, Сайхандулаан, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд, Улаанбадрах сумдын хүн эмнэлгийн барилгын засвар, тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, амрах байрны тохижилт зэрэг нийтдээ 103.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. “Тогтвортой амьжиргаа” төслийн хөрөнгөөр 2009 онд Айраг, Мандах, Өргөн, Улаанбадрах, Хатанбулаг сумдын соёлын төвүүдэд нийтдээ 65.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж, их засвар, тохижилтын ажлыг хийсэн, улсын төсвийн хөрөнгөөр	70

			Даланжаргалан сумын соёлын төвийн засвар, тохижилтын ажлыг хийсэн байна. “Саран хөхөө” театрын барилгын өргөтгөл, шинэчлэлтийг РЭМУГС ХХК гүйцэтгэж, 2010 оны 6 дугаар сард ашиглалтанд хүлээлгэж өгсөн. Сайншанд суманд Ёс заншил, өв соёл, хүндэтгэлийн ордны барилгыг 2010 оны 7 дугаар сараас “Сондуулт Эг” ХХК улсын төсвийн 200.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эхэлсэн. Барилгын суурийн ажил дуусч, ханын өрөг угсралтын ажил хийгдэж байгаа.	
124	2.5.10.1. Атрын 3 дахь аяны хүрээнд өндөр хүчин чадалтай трактор 725, үр тарианы комбайн 550-ийн нийлүүлнэ	2009-2012 ХХААХҮЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-

*ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗОРИЛТ*

№	Зорилт	Хугацаа	Биелэлтийн явцын тухай тэмдэглэл	хувь
125	3.2.1 Агаарын бохирдлыг бууруулах, чанарыг сайжруулах эрх зүйн орчныг шинэчилж, агаарын бохирдлыг бууруулах талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2010 БОАЖЯ	“Агаарын бохирдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр”-ийг аймгийн Засаг даргын 1999 оны 251 дүгээр захирамжаар баталсан, агаарын чанарын албыг аймгийн Засаг даргын 2007 оны 11 тоот захирамжаар байгуулсан. Аймгийн хэмжээнд нам даралтын 116 зуух ажиллаж, жилдээ 24,8 мянган тонн нүүрс түлдэг тооцоо бий. Мөн 13,4 мянган өрх айл ойролцоогоор 35,5 мянган тонн нүүрс түлдэг байна. Замын-Үүд, Сайншанд сумын төвийн нэгдүгээр бүсэд бага оврын зуух ажиллуулахгүй байх бодлого барьж, зохих шаардлага тавьж ажиллаж байна. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр шахмал түлшний үйлдвэрлэл эрхэлдэг „Амьдралын гал,, хоршооны үйл ажиллагааг дэмжиж БОАЖЯ-аас 2008 онд 6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосон. „Амьдралын гал,, хоршооны гаргаж буй шахмал түлшийг 30-40 өрх тогтмол авч хэрэглэдэг. Энэ үйлдвэрлэлийг аймгийн ЗДТГ-аас дэмжиж ЖДҮ-ийг дэмжих сангаас 5.0 сая төгрөгийн зээл олгуулсан	50
126	3.2.4. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас агаарт гарах тоосонцрын хаягдлыг бууруулах арга хэмжээ авна	2009-2012 БОАЖЯ	Дорноговь аймагт одоохондоо хамааралгүй	-
127	3.3.2 Томоохон суурин газрын цэвэрлэх байгууламжинд техник, технологийн шинэчлэл хийж, ашиглалтыг сайжруулан, стандартын шаардлага хангуулна	2009-2012 БОАЖЯ	„Хотуудын нийтийн аж ахуйг сайжруулах МОН-1907 төсөл,, тус аймагт хэрэгжиж, Сайншанд хотын бохир усыг байгалийн аргаар цэвэрлэх далан, хаалтуудтай болгосон. Мөн төслөөр гэр хорооллын зарим айл өрхийг цэвэр, бохир усны нэгдсэн шугамд холбох боломжийг бүрдүүлсэн. „Ариун цэврийн байгууламжийг сайжруулах,, хөтөлбөрийг 2009-2012 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн баталж, холбогдох газруудад хүргүүлэн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллаж байна.	50
128	3.4.2. Бүх аймгуудын хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 БОАЖЯ	Хатуу хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулах ажлыг одоогоор эхлээгүй байгаа	0

129	3.4.4 Бүсийн тулгуур төвүүдэд хог хаягдал дахин боловсруулах, томоохон хот, суурин газруудад хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, хог хаягдлыг булшлах ландфиллийн аргыг нэвтрүүлнэ	2009-2012 БОАЖЯ	Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэл одоогоор байгуулагдаагүй. 2010 онд улсын төсвийн 550,0 сая төгрөгийн хөрөнгөөр 4 аймгийн төвийн хог хаягдлын цэгийг ландфиллийн аргаар булаах, хөрсжүүлэх, талбайг багасгах ажлыг гүйцэтгэсний нэг нь тус аймаг байлаа. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах универсал трактор, авто ачигч, өөрөө буулгагчийг 116,9 сая төгрөгийн хөрөнгөөр “Төмөрт транс” ХХК нийлүүлсэн. 5 га газрыг шороон далан болон блокон хашаатай болгох, зарим талбайг хөрсжүүлэх, талбайн хэмжээг багасгах зэрэг ажлыг “Тохижилт Сайншанд” ХХК 20,6 сая төгрөгийн хөрөнгөөр гүйцэтгэж 2010 оны 11 дүгээр сард хүлээлгэн өгсөн.	30
130	3.5.2. Гол мөрний сав газрын зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж, сав газрын усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 БОАЖЯ	Дорноговь аймагт хамааралгүй	-
131	3.5.10 Усан сан бүхий газар ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ	2009-2010 БОАЖЯ	Усан сан бүхий газар тус аймагт байхгүй. Харин гүний усны худаг болон булаг шандны эхийг хамгаалах ажлыг зарим төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр шийдвэрлэж байна. “Тогтвортой амьжиргаа-2” төслийн 9,2 сая төгрөгийн хөрөнгөөр Айраг сумын төвд ундны усны худаг гаргасан, Алтанширээ сумын төвийн ундны усны худгийн хамгаалалтын барилга барьж, ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах ажлыг 11,1 сая төгрөгийн хөрөнгөөр “Атом маш” ХХК гүйцэтгэсэн, Замын-Үүд сумын төвд 16,6 сая төгрөгийн хөрөнгөөр усан сангийн 2 барилга барьсан. “Тогтвортой амьжиргаа-2” төслийн хөрөнгөөр Сайншанд, Алтанширээ, Айраг, Иххэт, Дэлгэрэх, Хөвсгөл, Мандах, Замын-Үүд, Замын-Үүд, Эрдэнэ сумдын төвийн ундны усны эх үүсвэрт хамгаалалттай болгосон	50
132	3.6.1 Хур тундасны усыг хуримтлуулах замаар усан сан, хөв, цөөрөм байгуулж, бэлчээр, хадлан, тариалан, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг дэмжинэ	2009-2010 БОАЖЯ	Айраг суманд 2, Иххэт суманд 1, Өргөн суманд 1, Улаанбадрах суманд 4, Эрдэнэ суманд 2, Сайншанд суманд 18, Замын - үүд суманд 4 нийт 32 ус хуримтлуулах усан сан байдаг. Үүнээс Мандах сумын Толлийн булаг, Айраг сумын Сайн-ус, Алтанширээ сумын Доньт булгуудыг мод, хүнсний ногоо тариалах зориулалтаар ашигладаг.	30
133	3.6.2. Ойжуулах, ногоон байгууламжийг өргөтгөх талаар аж ахуйн нэгж, ард иргэдийн санаачлага, төслийг санхүүгийн болон бусад хэлбэрээр дэмжинэ.	2009-2010 БОАЖЯ	Аймгийн хэмжээнд 2009 онд 36,6 мянган мод, бут, сөөгийг 26.9 га талбайд тариалж, 510 кв.м м <sup>2</sup> талбайг зүлэгжүүлсэн. Түүнд орон нутгийн төсвөөс 5,6 сая, аж ахуйн нэгж байгууллагаас 13,3 сая, нийт 18,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Түүнээс 23,7 мянган ширхэг суулгацыг БНХАУ-ын найрамдалт харилцаат муж, хотоос татан авсан юм. 2010 он Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар мод тарих үндэсний өдөртэй болсон, “Ойн менежментийг боловсронгуй болгох жил” болгон зарласан, “Монголоо ногооруулъя” аян зохион байгуулсан онцлогтой жил байлаа. Дээрхи бодлогын шийдвэр, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 44.3 мянган мод, бут, сөөгийг 30.9 га талбайд тариалж, энэ арга хэмжээнд сум, аймгийн орон нутгийн төсвөөс 21.1 сая, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хандивлагчдын 9.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Дорноговь аймгийн БОАЖГ Сайншанд сумын “Багадулаан трейд” ХХК, иргэн Б.Дэлгэрсайхан, Эрдэнэ сумын “Мөрөөдлийн говь” ХХК, Сайхандулаан сумын	50

			“Харцага бор” ХХК, Иххэт сумын “Баян хэт” хоршоо, Замын-Үүд сумын “Замын-Үүд” НААҮ ОНӨ ХХК-ийг Засгийн газрын “Ногоон хэрэм” хөтөлбөрийн гүйцэтгэгчээр сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан, эдгээр байгууллага, иргэд нийт 10 га газарт 9100 мод тарьжээ.	
134	3.7.1. Бэлчээрийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэн, говь, хээрийн бүсийн усны нөөцийн судалгаа явуулж, баг бүрт нар салхины эрчим хүчээр ажиллах нэг худаг гаргана	2009-2012 БОАЖЯ ХХААХҮЯ	„Тогтвортой амьжиргаа-2,, төслийн хүрээнд бэлчээрийн менежментийг сайжруулах ажил зарим суманд хийгдэж байна. Хөвсгөл сумыг загвар сумаар сонгон авч, бэлчээрийн менежментийн зураглал, төлөвлөгөө боловсруулж, бусад сумаас харьцангуй олон төсөл хэрэгжүүлсэн байна. “Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлагын сан” гэсэн бүрэлдэхүүний хүрээнд тус суманд өвс тэжээлийн нөөцийн сан байгуулах, мал угаалга, тарилгын бааз бэлтгэх, гар худаг гаргах, усны эх, булаг, шандны хайс хамгаалалт хийх, сүү, цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж нийлүүлэх, тэжээлийн ургамал тариалах зэрэг нийтдээ 45 бичил төсөл хэрэгжүүлж, 76.2 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ. Бусад суманд ихэвчлэн гар худаг гаргах, сэргээх, бэлчээр хаших зэрэг төсөл хэрэгжүүлж, нийтдээ 90.7 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр Нидерландын вант улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Цөлжилтийг бууруулах газрын тогтвортой менежмент” төсөл Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн сумдад хэрэгждэг. Төслийн хүрээнд элсний нүүдлийг сааруулах механик хаалт хийх, ургамлын гарц, бэлчээрийн даацыг тодорхойлох хяналтын цэг байгуулах, хадлангийн зориулалтаар бэлчээрийг хашаажуулах, булаг шанд тохижуулах зэрэг ажлыг хийж байна. Төслийн хүрээнд “Ард иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежмент, оролцооны арга” сэдэвт сургалтыг Сайншанд суманд зохион байгуулсан.	50
135	3.9.1 „Атрын 3 дахь аян,-ы хүрээнд ойн зурвас бүхий тариалан эрхлэлтийг дэмжиж урамшуулах бодлогыг хэрэгжүүлнэ	2009-2011 БОАЖЯ	Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын үр дүнд нилээд ахиц гарч байна. 2009 онд 183.7 тн төмс, 144.7 тн хүнсний ногоо хураан авч байсан бол 2010 онд 208,3 тн төмс, 277,5 тн хүнсний ногоо хураан авсан байна. 2010 онд хураан авсан төмс өмнөх оныхоос 11,3 хувь, хүнсний ногоо 91,4 хувиар тус тус нэмэгдэж, төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 22,0 хувийг аймгийн дотоодын ургацаас хангах боломж бүрдлээ. Эрдэнэ сумын “Арван наймын худаг” хэмээх газарт хүнсний ногоо тариалдаг “Мөрөөдлийн говь” ХХК, Сайншанд сумын орчинд тариалан эрхэлж байгаа “Бага дулаан трейд” ХХК-уудад БОАЖГ-аас хайлаасны суулгац нийлүүлэн, тариалангийн газрыг хамгаалах ойн зурвас байгуулах эхлэлийг тавиад байна.	30
136	3.14.2 Орон нутгаас тусгай хамгаалалтанд авах газар нутгийн шалгуур үзүүлэлт, үндэслэлийг шинэчлэн тогтоож, бүртгэл тооцоог Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн сүлжээнд хамруулна	2009-2010 БОАЖЯ	Тусгай хамгаалалттай газруудын талаарх мэдээлэл, тэдгээрийн солбицлыг цахим сүлжээгээр улсын нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэх ажил хийгдэж байна. Одоогоор улсын тусгай хамгаалалттай 5, аймгийн тусгай хамгаалалттай Хан Баянзүрх уул, Хашаатын говь, Далантүрүү, сумын тусгай хамгаалалттай Баянбуурал зэрэг газруудын дэлгэрэнгүй танилцуулга, талбайн зургийг оруулсан. Улаанбадрах сумын Аргалант уул, Хэцүүгийн майхан цав, Гурван бяруугийн хөндий, Харангат уул, Тахиаг, Өргөн сумын Аргалын уул зэрэг орон нутгийн хамгаалалттай газруудын талбайн координатыг нарийвчлан тогтоогоод байна.	50
137	3.14.8 Тусгай хамгаалалттай газар	2009-2010	Хамарын хийд, Хан Баянзүрх уул зэрэг орон нутгийн тусгай хамгаалалттай газарт үйл	

	нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүйг шинэчлэн боловсруулна	БОАЖЯ	ажиллагаа явуулж байгаа “Таван дохио” жуулчны баазын байршлыг улсын цахим мэдээллийн санд оруулсан. Тус жуулчны бааз өөрийн үйл ажиллагаандаа байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг “Монслов” ХХК-иар хийлгэсэн.	50
138	3.15.4 Нэн тэргүүнд ойжуулах, нөхөн сэргээх шаардлагатай газрыг тодорхойлж, 10,0 мянгаас доошгүй га газрыг ойжуулж, нөхөн сэргээнэ	2009-2010 БОАЖЯ	2010 он Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар мод тарих үндэсний өдөртэй болсон, “Ойн менежментийг боловсронгуй болгох жил” болгон зарласан, “Монголоо ногооруулья” аян зохион байгуулсан онцлогтой жил байлаа. Дээрхи бодлогын шийдвэр, зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд 44.3 мянган мод, бут, сөөгийг 30.9 га талбайд тариалж, энэ арга хэмжээнд сум, аймгийн орон нутгийн төсвөөс 21.1 сая, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, хандивлагчдын 9.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.	70
139	3.16.4 Нэн ховордсон ан амьтныг идээшсэн нутагт нь өсгөн үржүүлэх, тэдгээрийн генийн санг хамгаалахад биотехнологийн ололтыг ашиглана	2009-2012 БОАЖЯ	Даланжаргалан сумын Их Нарт байгалийн нөөц газарт байгаа аргаль хонийг судлах судалгааны төв 2000 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Тус судалгааны төв аргаль хонины сүргийн бүтэц, үржил генетикийн судалгаа явуулж, тайлан мэдээллээ БОАЖЯ-нд хүргүүлж байдаг юм.	50
140	3.17.3. Газрын нэгдмэл сангийн тайлангийн өгөгдлүүдийг боловсронгуй болгох, түүнд газрын ангиллын шилжилт хөдөлгөөнийг тусгах, байгаль орчны даац, чадавхид нийцүүлсэн газар зохион байгуулалтын урт хугацааны менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 ЗТБХБЯ	Дорноговь аймгийн газрын нэгдмэл санд хөдөө аж ахуйн газар 9707234,7 га /нийт сангийн 88,6 хувь/, хот тосгон, бусад суурины газар 25473,6 га /0,23 хувь/, зам, шугам сүлжээний газар 47865,4 га /0,44 хувь/, ойн сан бүхий газар 158432,0 га /1,45 хувь/, усан сан бүхий газар 27765,5 га /0,25 хувь/, улсын тусгай хэрэгцээний газар 980467,8 га газар /8,9 хувь/ байна. Нийт 585232,5 газрыг өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа нь өмнөх жилийнхээс газрын хэмжээ 492,8 га-гаар, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн тоо 705-аар нэмэгджээ.	50
141	3.17.5 Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөгөөр дамжуулан байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ	2009-2012 БОАЖЯ	Байгаль орчныг хамгаалах 2010 оны төлөвлөгөөний дагуу Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Өргөн, Иххэт, Мандах, Сайншанд, Сайхандулаан, Улаанбадрах сумдад нийт 47,6 га талбайд техникийн нөхөн сэргээлт, Алтагширээ суманд 2,0 га газарт биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Дээрхи арга хэмжээнд нийтдээ 433,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулжээ.	50
142	3.18.2 „Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр,, боловсруулж хэрэгжүүлнэ	2009-2012 БОАЖЯ	“Дорноговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны а/147 дугаар захирамжаар байгуулсан. Уг ажлын хэсэг хөтөлбөрийг эцэслэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн бариад байна. “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас 5,0 сая төгрөгийн хөрөнгө гаргаж аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 2000 ширхэг хэвлүүллээ. “Тогтвортой аялал жуулчлал, дагалт бизнесийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулсан үзэсгэлэнгийн нэг номинацид тус аймаг тэргүүн байр эзэлсэн. Аймагт аялал жуулчлалын холбоо 2010 оны 10 дугаар сард байгуулагдлаа.	50
143	3.18.3 “Аялал жуулчлалын маркетингийн стратеги төлөвлөгөө”	2009-2012 БОАЖЯ	“Дорноговь аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр” боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2010 оны а/147 дугаар захирамжаар байгуулсан. Уг	50



	боловсруулж, нэгдсэн бодлогоор гадаадад сурталчлах ажлыг зохион байгуулна		ажлын хэсэг хөтөлбөрийг эцэслэн боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхээр өргөн бариад байна. “Шинэ Дорноговь” хөгжлийн сангаас 5,0 сая төгрөгийн хөрөнгө гаргаж аймгийн аялал жуулчлалын газрын зургийг 2000 ширхэг хэвлүүллээ. “Тогтвортой аялал жуулчлал, дагалт бизнесийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулсан үзэсгэлэнгийн нэг номинацид тус аймаг тэргүүн байр эзэлсэн. Аймагт аялал жуулчлалын холбоо 2010 оны 10 дугаар сард байгуулагдлаа.	
144	3.18.4 Аялал жуулчлалын мэдээллийн сан байгуулж, салбарын статистик бүртгэлийг сайжруулна	2009-2010 БОАЖЯ	Улсын төсвийн 68,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хан хөхий” ХХК Хамарын хийдэд аялал жуулчлалын мэдээллийн төвийн барилга барьсан. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлал, амралт, сувилалын газар, аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж, нэгдсэн бүртгэлийн санд оруулж байгаа.	90
145	3.18.5 Жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэн, салбарын хүний нөөцийг хөгжүүлж, аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг олон улсын жишигт ойртуулна	2009-2012 ЗТБХБЯ БОАЖЯ	“Таван дохио” жуулчны бааз үйлчилгээний 4 гэрийг шинээр барьж, гэр рестораныг ашиглалтанд оруулсан, орчны гэрэлтүүлэг тавьж тохижуулсан, нийтийн тохилог ариун цэврийн өрөө, угаалгын газартай болсон байна. Эрдэнэ сум Бүрдэнэ булгийн сувиллын дэргэд аялал жуулчлалын бааз шинээр байгуулж, 2 байшин, 4 гэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. 2010 оны 5 дугаар сард аялал жуулчлалын улирлын нээлтийг Сайншанд суманд зохион байгуулсан, түүнд аялал, жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг 12 байгууллагын төлөөлөл оролцож, аялал жуулчлалын нөхцлөө хэрхэн сайжруулж, ямар үйлчилгээ үзүүлэхэд бэлтгэж байгаа тухайгаа иргэдэд мэдээллээ. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд жуулчны бааз 6, зочид буудал 35, орон нутгийн үзмэр үйлчилгээний газар 7, ресторан 13, баар, караоке 23 ажиллаж байна. Мөн жуулчны тээврийн үйлчилгээний 12 микро автобус, 68 таксийн жолооч тусгай зөвшөөрөл авч, жуулчдад үйлчилж байна.	50
146	3.18.6 Аялал жуулчлалын томоохон цогцолбор барьж байгуулахыг дэмжинэ	2009-2010 БОАЖЯ	Аялал жуулчлалын нэгдсэн цогцолбор байгуулах санаачлага одоогоор гараагүй байна. Харин Сайншанд хотод „Гандирс,, ХХК-ын “Дорноговь” нэртэй томоохон зочид буудал баригдсан нь аялал жуулчлалын нэгэн нөхцөл болж байгаа юм.	30
147	3.18.7 Түүх, соёлын болон адал явдалт, тусгай сонирхлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлж, аялал жуулчлалын эвент, арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлыг дэмжинэ	2009-2012 БОАЖЯ	Соён гэгээрүүлэгч Данзанравжаагийн шашин, түүх, соёлын дурсгал, говийн унаган байгалийг сонирхсон гадаад, дотоодын жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Өвлийн аялалын нэг бүтээгдэхүүн болох тэмээн поло наадмыг аймаг, сумдад зохион байгуулж хэвшиж байна. Аялал жуулчлалын чиглэлээр зохион байгуулагддаг бүсийн болон улсын чанартай томоохон арга хэмжээнүүдэд манай аймаг байнга, амжилттай оролцож байгаа. БОАЖЯ, Аялал жуулчлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан Mongolia ITF-2009 Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт тус аймгийн 8 аж ахуйн нэгж, байгууллага 27 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.	70
148	3.19.2 Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглахтай холбогдуулан аймаг, сумын Засаг даргын үүрэг хариуцлагыг өндөржүүлнэ	2009-2012 БОАЖЯ	Айраг, Алтанширээ, Даланжаргалан, Иххэт, Сайншанд, Сайхандулаан, Мандах, Улаанбадрах зэрэг сумдад байгаль хамгаалах чиглэлээр сумын Засаг даргын 33 захирамж гарсан байна. Мөн ИТХ-ын 11 тогтоол гарсан.	50
149	3.19.3 Ашигт малтмал олборлосон	2009-2012	Аймгийн хэмжээнд ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хяналт	

	газрыг нөхөн сэргээх стандартыг хэрэгжүүлж, хариуцлагын механизмыг боловсронгуй болгоно	БОАЖЯ	тавих, нөхөн сэргээх стандартыг хэрэгжүүлэх ажлыг хариуцаж зохион байгуулах үүрэгтэй бичил уурхайн ажлын албыг аймгийн ИТХ-ын 2009 оны 61 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын дэргэд байгуулж, түүний ажиллах журмыг баталсан. Мөн аймгийн Засаг даргын 2010 оны а/168 дугаар захирамжаар байгаль хамгаалах сан байгуулж, түүний журмыг баталсан. Уг сангийн хөрөнгийг байгаль орчныг нөхөн сэргээх, мод бут тарих санаачлагыг дэмжих зэрэгт ашиглаж байхаар тогтоосон болно.	50
150	3.19.4 Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, үйлчилгээнд тавих байгаль орчны болон олон нийтийн хяналтыг сайжруулна	2009-2012 БОАЖЯ	Аймгийн хэмжээнд идэвхтэн байгаль хамгаалагч 39, байгаль хамгаалагч 8, иргэдийн сайн дурын нөхөрлөл 11 ажиллаж, байгаль орчныг хамгаалах, ашигт малтмалын ордуудын нөхөн сэргээлтэнд хяналт ажилд оролцож байна. Сайхандулаан сумын Хашаат хэмээх газарт хууль бусаар, гар аргаар алт олборлож байсан 50 гаруй иргэний үйл ажиллагааг МХГ, Цагдаагийн газар шалгаж, тэдний ашиглаж байсан 18 ширхэг металл хайгчийг хураан авсан байна. Тус аймгийн нутаг дэвсгэр дээр гар аргаар алт, жонш олборлож байгаа иргэдийг нөхөрлөлийн хэлбэрт оруулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, нэгдсэн удирдлагатай болгох арга хэмжээ авч эхэлсэн. Одоогийн байдлаар Сайхандулаан сумын нутагт 20 хүний бүрэлдэхүүнтэй „Жавхланта түшиг“, нөхөрлөл байгуулагдаад байна. Аймгийн Засаг даргын 2010 оны а/167 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг /Цагдаагийн газар, МХГ, Тагнуулын хэлтэс, ОБХ, Татварын хэлтсийн ажилтнууд оролцсон/ Сайншанд сумын Зүүнбаян баг, Айраг, Даланжаргалан, Иххэт сумдад ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа 29 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна.	70

*ДӨРӨВ. ЭРХ ЗҮЙТ ТӨРИЙГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД,  
НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ЗОРИЛТ*

№	Зорилт	Хугацаа	Биелэлтийн явцын тухай тэмдэглэл	хувь
<b>4.1. Эрх зүйн бодлого</b>				
151	4.1.3.2 “Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг засаг захиргааны анхан, дунд шатны нэгж байгууллага бүрт хүргүүлэх арга хэмжээ авна	2009-2012 ХЗДХЯ	“Хууль зүйн мэдээлэл” сэтгүүлийг бүх сумын ИТХ, ЗДТГ захиалж албан хэрэгтээ ашигладаг. Төр, засгийн шинээр гаргасан хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хяналтанд авч, хэрэгжилтийг зохион байгуулан, биелэлтийн тухай мэдээллийг тогтоосон хугацаанд Засгийн газар болон бусад хэрэглэгчдэд нийлүүлж байлаа. Хэрэгжилтийн явц удааширсан тогтоол, шийдвэрийн тухай мэдээллийг аймгийн удирдлагуудад оруулж, холбогдох арга хэмжээ авч, хэрэгжүүлж ирсэн.	70
152	4.1.3.5 “Эрх зүйн туслалцааны төв”,-ийг аймгуудад байгуулж, үйлчилгээний хүрээг өргөтгөнө	2009-2012 ХЗДХЯ	Аймгийн Засаг даргын Тамгын газарт байрладаг эрх зүйн туслалцааны төв 2006 онд байгуулагдсанаас хойш тасралтгүй ажиллаж, иргэдэд хууль зүйн зөвлөгөө, лавлагаа өгч үйлчилж ирсэн. Эрх зүйн туслалцааны төвөөр 2010 онд 356 иргэн үйлчлүүлсэн, үүний дотор төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн 49 иргэн үнэ төлбөргүй үйлчилгээ авчээ. 31 өргөдөл, 15 гэрээ боловсруулахад нь иргэдэд тусалж, хууль зүйн цахим сангаас 234, гар сангаас 59 иргэнд лавлагаа, зөвлөгөө гаргаж өгсөн байна. Эрх зүйн туслалцааны төв албан бус сургалтыг 10 удаа, сэдэвт сургалтыг 13 удаа, сурталчилгааны ажлыг 20 удаа	50

			зохион байгуулж 1500 гаруй иргэдийг хамржуулжээ. Тус төв Хүний эрхийн аймгийн зөвлөлтэй хамтарч “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих сарын аян” зохион байгуулжээ.	
<b>4.2. Гэмт хэрэгтэй тэмцэх</b>				
153	4.2.10.3 Согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг, шалгалт тогтмол хийж, холбогдох арга хэмжээ авч байна	2009-2012 ХЗДХЯ	Архидан согтуурахтай тэмцэх “Эрчимжүүлэлт” “Шалгалт” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, энэ ажлын хүрээнд хууль бусаар болон зөвшөөрөлгүй цэгт архи, согтууруулах ундаа зарж байсан аж ахуйн нэгжүүдээс 190 шил архи, 405,5 л пиво, 15 л дарсыг хураан авч, зөрчил гаргасан 68 иргэн, 17 аж ахуйн нэгжийг 6060,0 мянган төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлого 349,9 мянган төгрөгийг хураан авч, 15 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Аймгийн ЗДТГ, МХГ, Татварын хэлтэс, СХЗХ, Ажил олгогч эздийн холбоо, Цагдаагийн газар хамтарч согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөлтэй 105 аж ахуйн нэгжид шалгалт хийснээс 23 аж ахуйн нэгж нь ямар нэг зөрчилтэй байжээ. Мөн Ханги Мандалын хилийн боомтод дээрхи үйлчилгээг үзүүлдэг байгууллагуудын үйл ажиллагаанд шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авчээ.	50
154	4.2.12.3. Ялтны МСҮТ байгуулж, ялтныг ажлын байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ	2009-2012 ХЗДХЯ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
<b>4.3. Хил хамгаалах бодлого</b>				
155	4.3.3.1 Улсын хил хамгаалах үүргийн 50 хүртэлх хувийг гэрээт хилчнээр гүйцэтгүүлэх арга хэмжээ авна	2009-2012 ХЗДХЯ	Улаан-Уул дахь ХЦ-ийн 0129-р анги, Замын-Үүд дэх ХЦ-ийн 0108-р анги, Сулинхээр дэх ХЦ-ийн 0168-р ангиудад 30 гаруй гэрээт цэргийн албан хаагч улсын хил хамгаалах үүрэг гүйцэтгэж байна. Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана. Орон нутагт хэрэгжилтийг үнэлэх боломжгүй	-
<b>4.4. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлэх</b>				
156	4.4.2.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн байгууллагуудыг нэгдсэн байртай болгох асуудлыг шийдвэрлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана	2009-2012 УБЕГ	Сайншанд суманд баригдаж байгаа ёслол хүндэтгэл, өв соёлын өргөөнд улсын бүртгэлийн байгууллагуудыг нэгдсэн байртай болгохоор өрөө тасалгааны хуваарь гаргаад байгаа. Нийтдээ 1410,2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй энэ объектийг 927,8 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Сондулт Эг” ХХК тендэрт шалгарсан. 2010 онд улсын төсвийн 400,0 сая төгрөгийн хөрөнгөөр барилгын суурь, зоорийн давхрын дам нуруу, хучилтын ажлыг гүйцэтгэж, төлөвлөсөн ажил 85,0 хувийн биелэлттэй байгаа, 2011 онд ашиглалтанд оруулж улсын бүртгэлийн үйлчилгээг уг ордонд явуулдаг болно.	70
<b>4.5. Иргэний нийгэм, төрийн удирдлагын бодлого</b>				
157	4.5.4.3 Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ	2009 ЗГХЭГ	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд тавигдах тусгай шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны албан тушаалд томилогдох ажилтныг нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулж байна. 2010 онд 10 байгууллагаас ерөнхий менежерийн ажлын байранд сонгон шалгаруулалт явуулах захиалга ирүүлснийг нийтэд зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулсан. Түүнд 58 хүн бүртгэгдэж шалгагдсанаас 47 хүн тэнцэж, 10 хүн томилогдож, 37 хүн нөөцөд бүртгэгдсэн.	50

158	4.5.4.4 Төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадвар дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт хамруулж, чадавхийг бэхжүүлнэ	2009-2012 ЗГХЭГ	Төрийн захиргааны манлайллыг дээшлүүлэх чиглэлээр Шведийн төслөөр 3 сургагч багшийг Удирдлагын академид бэлтгүүллээ. Эдгээр сургагч багш нар төсвийн байгууллагын ерөнхий менежерийн манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2010 онд аймгийн төвийн төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан, нэгжийн менежерүүд, хэлтэс, тасгийн дарга зэрэг 60 төрийн жинхэнэ албан хаагчдыг хамруулан сургалт зохион байгууллаа. 8 сумын нийт 40 ерөнхий менежерийг манлайллын шаталсан сургалтанд орон нутагтаа хамруулж, сертификат олгосон. Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг байгууллагууд өөр дээрээ тогтмол зохион байгуулдаг. Удирдлагын академийн төрийн захиргааны менежерийн сургалтанд 2010 онд 3, зорилтот сургалтанд 2 хүн суралцаж төгсгөлөө. Мөн менежерийн төлбөртэй сургалтанд 5 хүн, магистрийн сургалтанд хүн суралцсан. Төрийн удирдлага, нийгмийн удирдлагын дипломын сургалтанд 2, дипломын төлбөртэй сургалтанд 2 төрийн албан хаагч сургалтанд хамрагдаж мэргэжлээ дээшлүүлэх болоод байгаа юм. Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр, нийгмийн баталгааны хөтөлбөрүүдийг шинэчлэн мөрдөж ажиллаж байна.	70
159	4.5.4.5 Төсвийн байгууллагын тогтолцоо, бүтцэд судалгаа хийсний үндсэн дээр иргэдэд үзүүлэх төрийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр боловсронгуй болгох арга хэмжээ авна	2009-2012 ЗГХЭГ	„Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоох тухай,, Монгол улсын Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоол, „Аймгийн ЗДТГ-ын бүтцийг шинэчлэн тогтоох тухай,, Монгол улсын Засгийн газрын 2008 оны 67 дугаар тогтоолыг баримтлан аймаг, сумын ЗДТГ-ын бүтэц, орон тоог тогтоон ажиллуулж байна. Монгол улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор “Монгол мал” үндэсний хөтөлбөр баталж, 223 дугаар тогтоолоор сумдын ЗДТГ-т мал эмнэлэг, үржлийн албаны нэгж байгуулсан шийдвэрийг орон нутагт бүрэн хэрэгжүүлж ажиллаж байгаа.	70
160	4.5.5.1 Төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталж, ажил, үүргийн давхардал, хийдлийг арилгах, төсвийн зардлыг хэмнэх арга хэмжээ авна	2009-2012 ЗГХЭГ	“Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг,, явуулах тухай Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 37 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг шинээр болон шинэчлэн баталсан болно. Аймгийн Засаг даргын 2009 оны 189 дүгээр захирамжаар байгуулагдсан комисс 14 сум, 22 төрийн байгууллагад үзлэг явуулсан ба төрийн ажлын зохион байгуулалтын үзлэгээр аймгийн хэмжээгээр 79,4 хувийн үнэлгээтэй байжээ. Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг 2009 оны 10, 2010 оны 4, 5 дугаар саруудад бүх сумдад ажиллаж төрийн байгууллагуудын бүтэц нь төр засгийн болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд хэрхэн тохирч, уялдаж байгааг шалгаж танилцав.	70
161	4.5.5.2 Төрийн албан тушаал /ажлын байр/-ын чиг үүргийн шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр ажлын байрны тодохойлолтыг шинээр боловсруулан баталж мөрдүүлнэ	2009-2012 ЗГХЭГ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг түүний гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж батлан мөрдөж байна. Сумдын Засаг даргын Тамгын газар болон агентлаг байгууллагууд албан хаагчдынхаа ажлын байрны тодорхойлолтыг шинээр тогтоосон бүтцэд нийцүүлэн батлан ажиллаж байна. Сумын ЗДТГ-т мал эмнэлэг, үржлийн албаны нэгж байгуулсантай холбогдуулан тэдгээрийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг аймгийн ЗДТГ-ын захирамжаар баталж хүргүүллээ.	50
162	4.5.5.3 Гадаад, дотоод хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төсвийн	2009-2012 ЗГХЭГ	Төрийн албан хаагчийн ажлын үр дүнг хагас бүтэн жилээр дүгнэж урамшуулах, зэрэг дэв нэмэх зэрэг арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлж ирсэн. Аймгийн	50

	байгууллага бүрийг өөрчлөн хөгжүүлэх замаар байгууллагын шинэ соёлыг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, баталгааг хангах арга хэмжээ авна.		ЗДТГ-ын ажилтнуудын үр дүнгийн урамшилд 9,4 сая, гэр хороололд амьдардаг 5 ажилтанд нийт 600,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Сумдын ЗДТГ-ын ажиллах нөхцлийг сайжруулж засвар, тохижилтын ажлыг ээлж дараатай хийж, компьютер болон бусад техник тоног төхөөрөмжөөр хангаж байна.	
163	4.5.5.4 Төрийн албан дахь авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авч, энэ чиглэлээр үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоно	2009-2010 ЗГХЭГ	Аймгийн Засаг даргын 2009 оны 204 дүгээр захирамжаар “Авлигаас урьдчилан сэргийлэх талаар 2009-2010 онд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ирсэн. Төлөвлөгөөг боловсруулахдаа төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны талаар нийгмийн янз бүрийн төлөөллийг оролцуулсан санал асуулгыг бүх сумдад авсан юм. Аймгийн ЗДТГ-аас 4 удаагийн сургалт зохион байгуулж, төрийн болон төрийн буса байгууллагын 500 гаруй ажилтнуудыг оролцуулж, гарын авлага, лавлах материалаар хангасан. “Шудрага ёсны төлөө” аяны хүрээнд хуулийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, шудрага ёсны талаархи хэлэлцүүлэг явууллаа.	70
164	4.5.5.5 Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинэчлэн боловсруулж мөрдөнө	2009 ЗГХЭГ	Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулж, аймгийн Засаг даргын 2010 оны а/408 тоот захирамжаар батлан бүх сум, агентлагуудад хүргүүлсэн. Аймгийн ЗДТГ-аас 2010 оны 10 дугаар сард сумдад ажилласан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дээрхи дүрмийн талаар сумын төрийн албан хаагчдад сургалт явууллаа. Мөн Монгол улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг сурталчилж, хэрэгжүүлж ажиллаж байна.	90
165	4.5.5.6 Төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрмийг шинээр болон шинэчлэн боловсруулж мөрдөнө	2009 ЗГХЭГ	Төрийн тусгай ажил үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд ёс зүйн дүрмээ шинэчлэн мөрдөж байгаагийн дотр аймгийн Цагдаагийн газар ажилтнууддаа ёс зүйн талон гаргаж хяналт тавьж ажиллаж байна. Төрийн үйлчилгээний байгууллагууд дотоод журмаа шинэчилж, түүнд ажилчин албан хаагчдын ёс зүйтэй холбогдсон асуудлуудыг тусгасан байна.	50
166	4.5.6.6 ЗДТГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтнуудыг гадаад дотоодын сургалтанд хамруулж чадваржуулан, хяналт шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн түвшинг дээшлүүлнэ	2009-2012 ЗГХЭГ	Монгол улсын Засгийн газрын ХЭГ-ын ХШҮ-ний хэлтсээс 2009 оны 6 дугаар сард Өмнөговь аймагт зохион байгуулсан бүсчилсэн сургалтанд хяналт шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга, мэргэжилтний хамт оролцсон. Мөн 2009 оны 9-р сарын 28-аас 10 дугаар сарын 2-ны өдрүүдэд Удирдлагын Академи дээр хийлгэсэн сургалтанд тасгийн дарга оролцсон. 2010 онд Засгийн газрын ХЭГ-аас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ, үнэлгээний 10 алхам” нэртэй сургалтанд аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн мэргэжилтэн, ХХААХҮЯ-ны хяналт шалгалтын газраас зохион байгуулсан сургалтанд ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын мэргэжилтэн нар тус тус оролцсон. Эдгээр сургалтуудаас хяналт шинжилгээ, үнэлгээний онол, арга зүйн талаар зохих мэдлэг, мэдээлэл олж авсан.	70
167	4.5.7.2 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд орон нутгийн бие даасан байдлыг хангах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулна	2009 ЗГХЭГ	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдсон саналыг иргэд, байгууллагуудаас гаргуулж, хүлээн авч нэгтгэн Засгийн газрын ХЭГ, Сангийн яам, Дэлхийн банкны зээлийн төслийн нэгж, төвийн бүсийн хэлэлцүүлэгт хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн шинэчлэлд орон нутгийн бие даасан байдал, төсөв хөрөнгийн	-

			талаархи эрх мэдлийг дээшлүүлэх талаар тодорхой саналуудыг хүргүүлээд байгаа юм. /Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана, орон нутагт хэрэгжилтийн үнэлгээ гаргах боломжгүй/	
168	4.5.7.3 Орон нутгийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэн нутгийн өмчийн тухай бие даасан хуультай болгож, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно	2009-2012 ЗГХЭГ	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2010 онд 7 удаа хөрөнгийн асуудал оруулж шийдвэрлүүлэн, нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн тухай мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд байнга өгч байлаа. Зүүнбаян багийн 78 айлын орон сууц, Иххэт сумын бензин түгээгүүр зэрэг томоохон өмчийг ийнхүү шийдвэрлэсэн. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусдад түрээсээр эзэмшүүлж, 4,0 сая төгрөгийн түрээсийн орлого, 35,0 сая төгрөгийн хөрөнгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. 46,6 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 315,0 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасах шийдвэрийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан. Төрийн өмчийн хороо болон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 181,6 сая төгрөгийн хөрөнгийг төрийн өмчид шилжүүлсэн. Аймгийн ИТХ-ын дэргэдэх өмчийн алба аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтарч 9 сум, аймгийн Нэгдсэн эмнэлэг, “Чандмань илч” ОНӨ ХХК, “Саран хөхөө” театрын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд үзлэг, тооллого явуулж, дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.	70
169	4.5.7.4 Орон нутгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн жишиг сум шалгаруулах болзлыг баталж хэрэгжүүлнэ	2009 ЗГХЭГ	Сумдын хөгжлийн түвшнийг Монгол улсын Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоолоор баталсан хөгжлийн индексийг баримтлан тогтоохын тулд сумдаас холбогдох судалгаа, тайлан мэдээллийг гаргуулан авч судалгаа хийлээ. Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 193 дугаар тогтоолын дагуу сумдаас тайлан гаргуулан авч, ажлын хэсэг судалж үзээд Замын-Үүд сумын тодорхойлолт, холбогдох материалыг Засгийн газрын ХЭГ-т хүргүүллээ.	70
170	4.5.8.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлнэ	2009-2012 ЗГХЭГ	Аймгийн Засаг даргын 2009 оны 275 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Замын-Үүд сумыг орон нутгийн зэрэглэлтэй хот болгох талаар судалгаа, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулсан. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 54 дүгээр тогтоолоор Замын-Үүд сумыг орон нутгийн хотын зэрэглэлтэй болгох тухай саналыг Засгийн газарт уламжлаад байгаа, одоогоор тодохой шийдвэр гараагүй байна. /Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана, орон нутагт хэрэгжилтийн үнэлгээ гаргах боломжгүй/	-
171	4.5.10.1 Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны болон сонгосон зарим салбарын нийтлэг болон туслах чиг үүргийг хамарсан стратегийн чиг үүргийн шинжилгээг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах, бүтцийг боловсронгуй болгох, орон тоог цөөрүүлэх арга хэмжээ авна	2009-2012 ЗГХЭГ	Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана, орон нутагт хэрэгжилтийн үнэлгээ гаргах боломжгүй	-

ТАВ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН ЗОРИЛТ

№	Зорилт	Хугацаа	Биелэлтийн явцын тухай тэмдэглэл	Хувь
<b>5.1. Гадаад бодлого</b>				
172	5.1.1.14 Зарим улстай аймаг хотын шууд харилцааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2009-2012 ГХЯ	<p>Япон улсын Шизуока мужийн парламентийн гишүүн Окияанава тэргүүтэй □ОЙСКА□ төрийн бус байгууллагын төлөөлөгчид 2010 оны 5 дугаар сард тус аймагт ажлын айлчлал хийлээ.</p> <p>БНСУ-ын Төмөр замын сүлжээний хэрэг эрхлэх газрын дарга ноён Чо Хюён Ёнг тэргүүтэй албаны хүмүүс Сайншанд, Зүүнбаянд айлчлав. Тус айлчлалын бүрэлдэхүүнд Lotte, Daewoo, LG, Hyundai зэрэг дэлхийд алдартай компанийн төлөөлөгчид оролцсон бөгөөд Сайншандад аж үйлдвэрийн парк байгуулах, төмөр замын сүлжээг өргөтгөхөд хөрөнгө оруулалт хийж, хамтран ажиллах боломжийг судалж, аймгийн удирдлагуудтай санал солилцлоо.</p> <p>Аймгийн Засаг дарга П.Ганхуяг 2010 оны 10 дугаар сард Япон улсад ажлын айлчлал хийж, OISKA-International байгууллагын OISKA-Mongolia төрийн бус байгууллагын Ерөнхийлөгчийн хувьд төлөвлөсөн арга хэмжээнүүдэд оролцсон. Мөн Дорноговь аймаг Шизуока муж хоорондын хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав. Уг мужтай байгуулах хамтын ажиллагааны гэрээнд 2010 оны 11 дүгээр сард Монгол улсын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр аймгийн Засаг дарга гарын үсэг зурлаа. Шизуока мужийн захирагч Каваку Хэйтагийн Дорноговь аймагт хийх айлчлалын бэлтгэл хангахтай холбогдуулж Шизуока мужийн гадаад хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Макото Такахаши нарын төлөөлөгчид тус аймагт 2010 оны 11 дүгээр сард ажлын айлчлал хийв.</p> <p>ӨМӨЗО-ны Эрэн хотын дарга 2010 оны 6 дугаар сард тус аймагт ажиллаж 2 талын хамтын ажиллагааг өргөтгөх талаар ярилцаж, Эрэн хот өөрийн хөрөнгөөр аймгийн Хүүхдийн ордныг сэргээн засварлахаар тохиров.</p>	70
173	5.1.4.6 Хил, бүс нутгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх таатай нөхцлийг хангах талаар холбогдох талуудтай ажиллана	2009-2012 ГХЯ	<p>Аймгийн Засаг дарга БНХАУ-ын Эрэн хотын даргын урилгаар айлчилж “Бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулж, хоёр талын хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, Замын-Үүд суманд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар дөрвөн километр авто зам, цэцэрлэгт хүрээлэн байгуулах асуудлыг шийдвэрлэсэн. Мөн ӨМӨЗО-ны Бугат хотын Дархан муу мянган холбоот хошууны Засгийн газрын орлогч хошуу дарга Жэн Юань Биньтэй гэрээ байгуулж, Ханги Мандалын хилийн боомтыг хуваарийн бус цагаар ажиллуулах, цаашдаа байнгын ажиллагаатай болгох, боомтын тосгоныг Хятадын талын буцалтгүй тусламжаар бариулах, Сайншанд-Ханги Мандалын авто замын зураг төсөл боловсруулах зэрэг асуудлыг тусгаж хэрэгжүүлж ирсэн.</p> <p>БНХАУ-ын Эрэн хотын Аялал жуулчлалын газрын дарга болон олон улсын жуулчид хүлээн авах эрхтэй компанийн захирлууд аймгийн Засаг даргатай болон тус аймгийн зочид буудал, зоогийн газрын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн эзэдтэй уулзалт хийж, жуулчдыг хилээр тусгай гарцаар тусад нь дараалал үүсгэхгүй нэвтрүүлэх талаар зохицуулах, тэдний аюулгүй байдлыг хангах, Дорноговь аймгийн нутагт авто аялал хийх боломжийг судлах асуудлуудаар санал солилцов.</p>	70

			ӨМӨЗО-ны Бугат хотын Дархан муу мянган холбоот хошууны Засгийн ордон 1,0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Сайншанд-Зүүнбаян-Хөвсгөлийн чиглэлийн 160 км замын зураг төслийг боловсруулж Засаг даргад хүлээлгэн өгсөн. Аймгийн Засаг дарга ОХУ-ын Буриад улсын Иволгийн районы даргын урилгаар ажлын айлчлал хийж хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан.	
<b>5.2. Батлан хамгаалах бодлого</b>				
174	5.2.7.1 Дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтын чанарыг сайжруулж, оролцох бүрэлдэхүүнийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ	2009-2012 БХЯ	Дайчилгааны I, II зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг 2010 оны 10 дугаар сард Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн байнгын байрлал, сургалтын төвийг түшиглэн зохион байгууллаа. Мөн сумдын 60 багийн Засаг дарга нарыг оролцуулсан цэргийн бэлтгэл сургалтыг 2010 оны 5 дугаар сард Зэвсэгт хүчний 336 дугаар анги, Хилийн цэргийн 0129 дүгээр анги, хилийн заставуудыг түшиглүүлэн зохион байгуулсан.	70
<b>5.3. Гамшгаас хамгаалах, хор хөнөөлийг арилгах үндэсний чадавхийг бэхжүүлэх бодлого</b>				
175	5.3.2.3 Замын-Үүд суманд гал унтраах нэгж шинээр байгуулна	2010-2012 ОБЕГ	Монгол улсын Засгийн газрын 2009 оны 322 дугаар тогтоолоор Замын-Үүд суманд аврах, гал унтраах 17 дугаар анги, Айраг суманд гал унтраах 23 дугаар ангийг 2010-2011 онд байгуулахаар шийдвэрлэсэн. Замын-Үүд сумын аврах, гал унтраах ангийн барилгын нийт төсөвт өртөг 882.0 сая төгрөг бөгөөд 2010 онд 270.0 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрлэгдэж, “Наранбулаг трейд” ХХК гүйцэтгэгчээр ажиллаж байна.	50
176	5.3.4.2 Төв, орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг сайжруулж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна	2010-2012 МХЕГ	Аймгийн Мэргэжлийн хяналтын газар Төрийн хяналт шалгалтын тухай болон салбарын бусад хууль тогтоомжийг удирдлага болгон хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, ажиллах, чанартай бүтээгдэхүүн хэрэглэх, хөдөлмөрлөх эрхийг хангах, бизнес эрхлэгчдийн таатай орчинг бүрдүүлэх, төрийн өмчийн болон төсвийн байгууллагуудад санхүүгийн сахилгыг дээшлүүлэх үндсэн зорилгоо бүрэн хэрэгжүүлж ирсэн. 2009 оны үйл ажиллагааны үр дүнгээр 91,6 хувь /шаардлага бүрэн хангаж байгаа/ гэсэн үнэлгээгээр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас 3 дугаар байр эзэлсэн. 2010 онд төсвийн 376, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой 88, орон нутгийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 115, хувийн хэвшлийн 2058, бусад 131, бүгд 2768 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Төсөвт нөхөн төлүүлэхээр 69,2 сая төгрөгийн төлбөр тогтоосны 54,7 хувийг, 20,8 сая төгрөгийн торгууль, шийтгэл оногдуулсны 80,7 хувийг тус тус барагдуулаад байна.	70
177	5.3.4.3. Хилийн боомтуудын мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын орон тоог нэмэгдүүлж, зайлшгүй шаардлагатай багаж, техник хэрэгслээр ханган, ажлын болон ахуйн байртай болгоно.		Төр, засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана, орон нутагт хэрэгжилтийн үнэлгээ гаргах боломжгүй	-
<b>Гүйцэтгэлийн дундаж хувь</b>				<b>56,8</b>
<b>Үнэлгээний оноо</b>				<b>2,84</b>



**Товчилсон үг:**

НХХЯ-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам  
ЭМЯ-эрүүл мэндийн яам  
ХТГ -Хүүхдийн төлөө газар  
ХХААХҮЯ-Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэрийн яам  
ЭБЭХЯ -Эрдэс баялаг, эрчим хүчний яам  
ЗТБХБЯ - Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам  
БСШУЯ- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам  
СЯ-Сангийн яам  
ҮХШХ-Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо  
МХЕГ-Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар

ШЄХТГ - Шудрага ерселдсэн, хэрэглэгчдийн төлөө газар  
СХЗГ - Стандартчилал, хэмжил зүйн газар  
БОАЖЯ- Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
ХЗДХЯ -Хууль зүй, дотоод хэргийн яам  
УБЕГ -Улсын бүртгэлийн Ерөнхий газар  
ЗГХЭГ-Засгийн газрын Хэрэг эрхлэх газар  
ГХЯ- Гадаад харилцааны яам  
БХЯ -Батлан хамгаалах яам  
ОБЕГ -Онцгой байдлын ерөнхий газар

**Тайлбар:**

Зорилт тус бүрийн гүйцэтгэлд хувь тавихдаа Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2010 оны 10 дугаар сард тус аймагт хийсэн хяналт шалгалтын ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг үндэслэн аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын хэдэн хувийг биелүүлээд байгааг харуулахыг хичээсэн болно.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2011 оны 02 дугаар сарын 05-ны өдөр